

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ТАВДУГААР САРД  
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ**

**НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДЫН ХУРАЛ ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБА**

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Дорноговь Аймгийн Шүүхийн Шинжилгээний Албанд дижитал микроскоп хүлээлгэн өгсөн.

Дэлхийн банк болон ДЗМОУБ-ын хамтран хэрэгжүүлж буй "Монгол улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийг эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" (MASAM II) төслийг Дорноговь аймагт хэрэгжүүлэхээр сонгогдсон Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй төрийн байгууллагууд уулзсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв нь төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрийн үйлчилгээг тасралтгүй түргэн шуурхай явуулах, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Тус төвийн ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Дорноговь аймагт ажилласан.

Энэ өдөр аймгийн Засаг дарга О.Батжаргал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Ц.Батсугир, Засаг даргын Тамгын газрын дарга Н.Хонгорзул, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ч.Нандин-Эрдэнэ нар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзан Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн тус суманд хууль зүйн туслалцаа үзүүлэх танхим байгуулахаар шийдвэрлэсэн.

Сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох, зөв дадал олгох, хэвшүүлэх, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, хууль дүрмийг сурталчлах зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын ивээл дор "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнийг Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас зохион байгуулсан.

"Мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөр", Монгол улсад "Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ой"-н хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн санаачилгаар байгуулсан "Иргэдийн цэцэрлэгт хүрээлэн"-д мод тарьсан.

Тус арга хэмжээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон ажлын албаны бүрэлдэхүүн оролцож, 200 ширхэг хайлаас мод суулгасан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүжилтээр аялал жуулчлалын идэвхтэй улирал эхэлж байгаатай холбогдуулан Хамарын хийд, Ханбаянзүрх хайрханыг зорин ирэх иргэд, жуулчдын тоо нэмэгдэж байгаа тул Сайншанд сумын Цагаан хаалганы дэргэд нийтийн бие засах газрын асуудлыг шийдвэрлэсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гуравдугаар хуралдаан болсон. Хуралдаанаар аймгийн ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан:

Хамтарсан багийг чадавхжуулах сургалт

Мэргэжилтний багийн сургалт

Замын хөдөлгөөний Цагаан толгой тэмцээн

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний хагас жилийн гэмт хэргийн гаралт, өсөлт бууралтын талаарх тайлан мэдээг тус тус сонссон.

Тайлан мэдээнд тулгуурлан салбар зөвлөлийн гишүүдэд

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил

Архидан согтуурахтай тэмцэх зохион байгуулалтын ажил

Хүүхдийн хүчирхийллийг бууруулах, зорилтот бүлэгт чиглэсэн судалгаа, тоон мэдээлэл гаргаж, нөлөөллийн ажил зохион байгуулах талаар зөвлөлийн дарга үүрэг болгосон.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн телекамерын хяналтын дэд төвийн засварын ажил, аймгийн Цагдаагийн газарт архи, согтууруулах ундааг шалгах төхөөрөмж авахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Ганзориг Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба болон Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, цаг үеийн мэдээллийг авч ажилласан.

Тус сумын Цагдаагийн хэлтсийн телекамерын хяналтын дэд төвийн засвар, үйлчилгээний төсөв болох 17,529,000 төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гуравдугаар хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд тус хөрөнгөөр хийгдэж буй ажлын үйл явцтай танилцсан.

Шинээр байгуулагдах телекамерын хяналтын дэд төв нь Замын-Үүд сумын иргэдийн амар тайван амьдарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг гэмт халдлага, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах зорилгоор 70 цэгт байршуулсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 8 дахь удаагийн Хурал нь 2020 оны 10 дугаар сараас хойш нийт 10 нэхэмжлэгчийн өргөдлийг зохих шатны шүүхийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж, цагаатгалын нөхөх олговрын мөнгийг олгоод байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Ганзориг, төлөөлөгч П.Бямбанаранжав нарын санаачлагаар Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Шинэ жилийн баярыг угтсан “Жаргалтай гэр бүл” арга хэмжээ уулзалтыг 2-р багийн иргэдийн дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Энэ жил төлөөлөгчдийн тойрогтоо хийж буй ажлын нэг хэсэг болсон тус үйл ажиллагаагаар 300 хүүхдэд бэлэг гардуулж, баярын мэнд дэвшүүлсэн.

**Аймгийн ИТХ-ын даргын шагнал:** 05 дугаар сард аймгийн ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр нийт 5 хүн шагнуулсан.

**Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тогтоол:** 05 дугаар сард аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс нийт 7 тогтоол баталсан.

**Аймгийн ИТХ-ын даргын захирамж:** 05 дугаар сард аймгийн ИТХ-ын даргын нийт 18 захирамж гарснаас ангилбал Буцалтгүй тусламж олгох тухай-1, Зардал гаргах тухай-5, Зардал батлах тухай-3, Шагнах тухай-2, Дэмжлэг үзүүлэх тухай-7 болно.

**Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал:** 05 дугаар сард аймгийн ИТХ-ын нарийн бичгийн нийт 10 тушаал гарснаас ангилбал Буцалтгүй тусламж олгох тухай-1, Хөрөнгө зарцуулах тухай-5, Ажилд томилох тухай-2, Ажлаас чөлөөлөх тухай-1, Албан тушаалын тодорхойлолт батлах тухай-1 болно.

**Аймгийн ИТХ-ын ажлын албанд ирүүлсэн албан бичиг, өргөдөл:** Аймгийн ИТХ-ын ажлын албанд нийт 47 албан бичиг ирж, ажлын албанаас нийт 25 албан бичиг бусад

байгууллагад хүргүүлсэн байна. Иргэдээс аймгийн ИТХ-д нийт 4 өргөдөл ирүүлснийг 2 өргөдлийг хугацаанд бүрэн шийдвэрлээд байна.

## **ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗАР**

### **2.1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хүний нөөц, сургалтын чиглэлээр:** Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын дарга нарын болон сумдын Засаг дарга нарын ээлжийн амралтын саналыг авч нэгтгэн аймгийн Засаг даргын 2022 оын А/180 дугаар захирамжаар, аймгийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/23 дугаар тушаалаар тус тус баталсан.

Удирдлагын академиас зохион байгуулж буй эрхэлсэн болон ахлах түшмэлийн багц сургалт, төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтуудад сурч байгаа болон өмнө нь хангалтгүй суралцсан төрийн албан хаагчдын талаар холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлсэн.

Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн системд төрийн албан хаагчдын албаны цахим хаяг, зэрэг дэвийн нэмэгдэл, цалингийн өөрчлөлт болон шинээр томилогдсон 2 албан хаагчийн мэдээллийг бүрэн хийсэн.

Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 сул орон тоог тусгай шалгалтаар нөхөхөөр захиалгыг хүргүүллээ.

Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын дагуу 12 сумын Засаг даргын Тамгын газрын болон зарим агентлагуудын тэмдэгийг сольж тамга хийлгэх зөвшөөрөл хүсэхалбан бичгийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Сайншанд, Замын-Үүд сумаас бусад сумдын Засаг даргын Тамгын газрын Дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалыг Олон нийттэй харилцах, дотоод ажил хариуцсан ажилтан гэж өөрчлөн, албан тушаалын ангиллыг ТЗ-3 байсныг ТҮ-7 болгох саналыг аймгийн удирдлагад танилцуулан захирамжийн төсөл боловсруулсан.

Өндөр насны тэтгэвэрт гарч төрийн албанд ажилласан жилд ногдох тэтгэмж авахыг хүссэн 2 иргэний материалыг судлан тэтгэмж олгох шийдвэрийг гаргасан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/147 дугаар захирамжаар төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олголоо. Нийт 66 албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгоод байна. Үүнтэй холбогдуулан аймгийн Заасаг даргын Тамгын газрын зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон албан хаагчдыг зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны А/20 дугаар тушаалыг батлан гаргасан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан шинээр бий болсон ажлын байрны албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулан хянуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

"7 хоногийн мэдээллийн цагт хэлтсүүдийн мэдээлэл хийх журам", "Ажил хүлээлцүүлэх журам"-ын төслийг тус тус боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/32, А/33 дугаар тушаалаар тус тус батлуулсан.

### **Өргөдөл гомдол, шагналын чиглэлээр:**

Иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж бичгээр ирүүлсэн 116 өргөдлийг хүлээн авч, өмнө хүлээн аваад судлагдаж байсан 18 өргөдөлд хариуг өгч, 16 өргөдөл судлагдаж байна.

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирүүлсэн 55 өргөдлийг хүлээн авч 34-ийг шийдвэрлэн хариуг өгсөн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүлээн авах утсаар долоон иргэний өргөдөл саналыг хүлээн авч судалж шийдвэрлэх хэлтэс албан тушаалтанд шилжүүлэн 4 өргөдлийг шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 241 гаруй санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Энэ сард иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзвэл санал, хүсэлт - 98 хувь, талархал нэг, гомдол нэг хувийг тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 94 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 4 хувь нь хугацаа болоогүй судлагдах шатандаа байна.

Энэ сард Монгол Улсын цол хүртээх, төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар сумдаас ирүүлсэн 84 иргэний материалыг зохих журмын дагуу шалгаж, шагналд нэр дэвшүүлэх санал авахаар харъяалах төрийн төв байгууллагад хүргүүлсэн.

Засгийн газрын салбарын тэргүүний ажилтнаар нэр нь дэвшсэн 2 иргэний шагналын материалыг хүлээн авч шалган холбогдох яамдад уламжлав.

"Алдарт эх" нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар сумдын Засаг даргаас ирүүлсэн тодорхойлолт, бусад материалыг хүлээн авч аймгийн хэмжээнд нийт 259 эх "Алдарт эх" нэг, хоёрдугаар одонгоор шагнагдах болзол шаардлагыг хангасан ба эдгээрийн 21 эх нь "Алдарт эх" нэгдүгээр зэргийн одонгоор, 238 эх "Алдарт эх" хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах болзлыг хангасан байна. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс болон Замын-Үүд сумандаа гардан авах эхчүүдээс бусад эхчүүдэд 06-28 өдөр Сайншанд суманд нэгдсэн ёслолын арга хэмжээ зохион байгуулж гардуулав. Аймгийн хэмжээнд нийт 17 эх өөрөө болон хүүхэд эмнэлэгт хэвтэж байгаа, гадаад улсад амьдарч байгаа, "Ковид-19"-ийн тусгаалал-танд байгаа зэрэг шалтгаанаар хүрэлцэн ирж амжаагүй байна.

#### **Мэдээллийн технологийн чиглэлээр:**

Замын-Үүд суманд төрийн үйлчилгээний лавлах (7777-5525) call center үйлчилгээг нэвтрүүлж ажилласан.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн "ERP" системийн заавар зөвлөмжийг 13 байгууллагын 45 албан хаагчдад утсаар болон танхимаар өгч ажилласан. 4 сумд албан ёсны цахим хуудастай болгох ажлыг зохион байгуулсан.

Сайхандулаан, Айраг суманд төрийн операторын үйлчилгээ ажиллуулахад шаардалгатай тоног төхөөрөмжийг өгч нийт 14 суманд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх боломж бүрдсэн.

#### **Архивын чиглэлээр:**

Байгууллагын 2022 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулах саналыг зохион байгууллалын нэгжээс авч нэгтгэн БНШК-оор оруулахаар бэлтгэж байна.

Байгууллагын 2021 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу зохион байгуулалтын нэгжээс 2021 оны баримт 4 хэлтэсээс нийт 235 баримт хүлээн авч байна, 70 жил, түр хадгалах бүртгэл үйлдсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаал батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын Архивын журмын төслийг боловсруулж бэлтгэсэн.

#### **Албан хэргийн чиглэлээр**

Албан байгууллагуудаас Дорноговь аймгийн засаг дарга , Тамгийн дарга болон бусад хэлтэст нийт 304 албан тоот ирж 141 албан бичиг Албан байгууллагууд болон хувь хүнд хүргүүлж ажилласан байна. Үүнээс харилцсан бичиг 32 ирэснийг хариу хүргүүлж ажилласан байна.

- Үүнд энэ сард хугацаа хэтсэрсэн бичиг 2 бичиг ХОХБТХэлтэсээс явуулсан байна.
- Хугацаандаа явуулсан 30 бичиг байна..

### **Онцгой байдлын газар:**

**Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлсэн талаар:** Монгол улсын Шадар сайдын баталсан удирдамж, Уул уурхай, баяжуулах үйлдвэрт гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтаар 18 аж ахуйн нэгжийн нийт 94 зөрчил илрүүлэн, газар дээр нь арилгах боломжтой 46 зөрчлийг арилгуулан, албан шаардлага 13, ажиллагаа зогсоох тогтоол 1 бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.

Зөрчлийн тухай хуулийн 5.14.1 дэх заалт галын аюулгүй байдлын дүрэм, журам, галын аюулгүй байдлыг хангах талаар тавигдах нийтлэг шаардлагыг зөрчсөн 1 иргэнд 100,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулан прокурорын байгууллагад бүртгүүлэн тэмдэглэл хөтөлсөн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/192 дугаар захирамжийн дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар, Хотын захирагчийн ажлын алба, Хөгжлийн бодлогын хэлтэс, Хамрын хийдийн тусгай хамгаалалтай газрын захиргаа, Сайншанд-хот тохижилтын газар, аймгийн Цагдаагийн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран Сайншанд сумын нутаг дэвсгэрт хамаарах Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын жуулчны бааз, гэр буудал, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтад Хамарын хийдийн 7 иргэний гэр буудал, 1 аж ахуй нэгж байгууллага хамрагдсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 8 удаа өгч ажилласан.

Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан иргэн,аж ахуй нэгжийн барилга байгууламжийн галын аюулгүй байдал, Монгол улсын “Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм журам түүнтэй нийцүүлэн гаргасан норм, стандартын хэрэгжилт галын аюулаас хамгаалагдсан байдалд хяналт шалгалт хийж Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны А/154 дугаар тушаалын дагуу Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 15 удаа олгож орон нутгийн төсөвт 537,500 төгрөг төвлөрүүлсэн.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт баригдах “Архидеа” ХХК-ийн “Цогцос хадгалах барилга”-ын ажлын зураг, Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдах “Эрдэнэ Ажнай” ХХК-ийн өргөтгөлийн ажлын зургийг хянаж баталгаажуулж, зураг төсөл хянасан дүгнэлт гарган Орон нутгийн төсөвт 100,000 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

### **АНГИЛЛЫН СУРГАЛТЫН ТАЛААР**

**Удирдах бүрэлдэхүүний сургалт:** Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Хөвсгөл, Дэлгэрэх сумын Онцгой комиссын гишүүдэд “Гамшгийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний төлөвлөлт”, “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах

журам”, “Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүтэц зохион байгуулалт” сэдвээр гамшгаас хамгаалах ангиллын удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулахад нийт 45 алба хаагч хамрагдсан.

Сайхандулаан суманд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд оролцогчдын мэдлэгийг дээшлүүлэх, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах зорилгоор “Гамшгаас хамгаалах менежмент”, “Гамшгийн нөхцөл байдал”, “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн чиг үүрэг, удирдлага зохион байгуулалт”, “Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр 4 цагийн танхимын сургалт зохион байгуулахад удирдах бүрэлдэхүүнээс нийт 21 алба хаагч хамрагдсан.

Мандах суманд зохион байгуулсан гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгээр сумын Онцгой комиссын гишүүд, удирдах бүрэлдэхүүнд “Гамшгаас хамгаалах менежмент”, “Гамшгийн нөхцөл байдал”, “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн чиг үүрэг, удирдлага зохион байгуулалт”, “Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр 3 цагийн танхимын сургалт зохион байгуулахад нийт 16 алба хаагч хамрагдсан.

**Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтаны сургалт:** Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/133 дугаар тушаал, Онцгой байдлын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, дундаж үзүүлэлтийг хангах, аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сурталчлан таниулах, гамшиг осол тохиолдоход өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах ухаанд сургах, мэдлэг, чадвар олгох, бэлэн байдлыг хангуулах зорилгоор “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Гал унтраагуур ашиглах заавар, зөвлөмж” сэдвээр “Мэдээлэл холбоо ХК”-ний 8 ажилтан, алба хаагч нарт гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг танхимаар зохион байгуулсан.

**Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд:** Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээ, аймгийн Засаг даргын 2022 оны А/58 дугаар захирамжийн хүрээнд Сайхандулаан суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд нийт 320 иргэд, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги 67 томилгоот бүрэлдэхүүн, 13 нэгж, техник дадлага сургуульд хамрагдсан байна.

**Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд:** “Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын байгууллагын хэрэгжүүлж буй Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Онцгой байдлын үед мал, амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар стандарт /LEGS/-ийн сургалтыг Хөвсгөл, Дэлгэрэх суманд орон нутгийн чиглүүлэгч нарын хамт сумын “Онцгой комисс”, “Засаг даргын Тамгын газар”, “Эрүүл мэндийн төв”, “Ерөнхий боловсролын сургууль”, “Багийн Засаг дарга” нарыг оролцоотой зохион байгуулсан.

Сургалтын хүрээнд сумын Онцгой комиссын гишүүд, Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд “Гамшгийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний төлөвлөлт”, “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах журам”, “Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүтэц зохион байгуулалт” сэдвээр сургалтыг зохион байгуулахад нийт 45 алба хаагч хамрагдсан.

**Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд хийсэн талаар:** Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

хийх журам, Монгол улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх зааврын дагуу Сайхандулаан, Мандах сумдын удирдлага, мэргэжлийн ангийн нийт бие бүрэлдэхүүнд Гамшгийн эрсдэлийн талаарх ерөнхий ойлголт, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх хэрэгцээ шаардлага, хууль, эрх зүйн орчин сэдвүүдээр сургалт хийсэн.

Улмаар индикаторын аргачлал ашиглан зонхилон тохиолдож болох гамшгийн 8 төрлөөр гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, үнэлгээний тайланг боловсруулахаар ажилласан.

**Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг аж ахуй нэгж, байгууллагын түвшинд хийсэн талаар:** Дээрх хууль, журам, зааврын дагуу 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Сайхандулаан сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, багш, ажилчдын төлөөлөл бүхий нийт 21 хүн /ЕБС-12, цэцэрлэг-9/-ий бүрэлдэхүүнтэйгээр, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Мандах сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, багш, ажилчдын төлөөлөл бүхий нийт 28 хүн /ЕБС-17, цэцэрлэг-11/-ий бүрэлдэхүүнтэйгээр гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн.

#### **Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Онцгой байдлын ерөнхий газар, Ус, Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг хүлээн авч малчид, иргэд олон нийтэд шуурхай хүргэх ажлын зохион байгуулж албаны цахим хуудсанд /3/ удаагийн мэдээлэл байршуулан малчид, иргэдэд дамжуулсан байна.

Сэрэмжлүүлэх мэдээг дамжуулсан тухай илтгэх хуудсыг Онцгой байдлын ерөнхий газар болон Өмнөд бүсийн төв рүү заасан хугацаанд хоцрогдолгүй хүргүүлж ажилласан.

**Мэдээ, мэдээлэл хүргэсэн байдал:** Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газарт өдөр бүрийн 17:00 цаг бүрт Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан тухай хүснэгтэн мэдээг хүргүүлж ажилласан.

Албаны Фэйсбүүк болон фейж хуудсанд цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээлэл-8, [Dg.nema.gov.mn](http://Dg.nema.gov.mn) вэб сайтад /6/ удаа нийтлэж иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан.

**Гал түймрийн дуудлагаар ажилласан байдал** Тайлант хугацаанд гал түймрийн 2 дуудлагаар Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 17, 23 дугаар ангийн 8 алба хаагч 2 техник хэрэгсэлтэй ажиллаж, 7 тн ус, 29.34 л шатахуун зарцуулан унтраасан. Гал түймрийн улмаас өмч хөрөнгийн хохиролгүй 5,000,000 төгрөгийн эд хөрөнгө авран хамгаалсан.

### **Мэргэжлийн хяналтын газар**

#### **1. Хүнс хөдөө ахуйн хяналтын чиглэлээр:**

1. Аймгийн Мал эмнэлгийн газраас ирүүлсэн 2022 оны 227, 229 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу 3, 4-5 сард аймгийн хэмжээнд хийгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын материалыг /600-700хуудастай/ хянаж, улсын байцаагчийн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.

2. МХЕГ-ын даргын 2022 оны 01/03 дугаартай удирдамжийн хүрээнд Хүүхдийн баяр болохтой холбогдуулан Хүнсний чанар стандарт, мал эмнэлэг, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр Сайншанд суманд байрлалтай Гуа бурхант ХХК, Авлай хайрхан ХХК, Оргих хүнсний бөөний дэлгүүр, Угалз ХХК, Мичид хүнсний дэлгүүр зэрэг 15 дэлгүүр, Замын –Үүд суманд байршилтай 11 дэлгүүрийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж гүйцэтгэж байна.

Шалгалтаар:

- Ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаагүй
- Ажлын байранд хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэж хэвшээгүй
- Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн болон хагас боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалаж худалдаалдаггүй, Хаяг шошгын зөрчилтэй бүтээгдэхүүн худалдан борлуулж байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг цаашид гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөн зөрчлийг арилгуулан ажиллалаа

## **2. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:**

МХЕГ-н даргын баталсан 01/51 дугаар төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Сайншанд, Өргөн, Эрдэнэ сумдад шинээр баригдаж буй 11 барилгын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 13 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан 5 албан шаардлага хүргүүлсэн.

Сайншанд сумын засаг даргын 2022 оны 05 сарын 25-ны өдөр баталсан захирамжийн дагуу сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Тусгай хамгаалалттай газрын захиргаа, Татварын хэлтэстэй хамтран Сайншанд сумын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 10 иргэнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

МҮХУБ-тай хамтран Хөвсгөл суманд мал эмнэлгийн чиглэлээр шинээр үйл ажиллагаа эрхлэх гэж буй Булаг вет ХХК, Сайхандулаан суманд мал эмнэлгийн чиглэлээр шинээр үйл ажиллагаа эрхлэх гэж буй Алаг жавхлант ХХК-д дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

## **3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрчим хүч, Барилгын техникийн хяналтын чиглэлээр:**

МХЕГ-ын 2022 оны 04 сарын 12-ны 01/51 урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Сайншанд сумын 640 хүүхдийн сургууль, Саран хөхөө театр, Гандирсын 7 давхарын барилга, Сайхандулааны Соёлын төв, Айраг сумын Соёлын төв, Эрүүл мэндийн газар, ЕБС-ийн барилга, Даланжаргалан сумын Соёлын төв, ЕБС-ийн барилга ашиглалтын төлөв байдал, угсралтын явцад БТХУБ хяналт шалгалт хийн ажилласан.

- Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/55 дугаартай удирдамжийн хүрээнд Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргасан цацрагийн үүсгүүр ашигладаг Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг, Шонхор мед зэрэг эмнэлгүүдэд Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.6-д заасны дагуу цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, хөтөлбөр, төлөвлөгөө, цацрагийн ослын төлөвлөгөөг хянан баталгаажуулж ажилласан.

- Итгэмжлэгдсэн лаборатори:

Сорилтын лабораторид 32 аж ахуйн нэгж иргэний хүсэлтээр 53 дээжинд 295 үзүүлэлт тодорхойлсон ба 18 үзүүлэлт стандартын шаардлага хангаагүй гарсан.

## **4. Салбарын болон дотоодын сургалт**



Эрдэнэ, Өргөн, Айраг, Даланжаргалан, Сайхандулаан, Мандах сумдад хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд "Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах тухай", "Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх нь", "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага" сэдэвт, сумын Эрүүл мэндийн төвд "Эрүүл мэндийн байгууллагуудад нийтлэг илэрч байгаа дутагдал, шалтгаан, нөхцөл, арилгах арга зам", "Эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулахад анхаарах нь" сэдэвт сургалтуудыг хийлээ. Сургалтад 28 аж ахуйн нэгж, 96 иргэн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаартай захирамжаар баталсан "Хүүхэд хөгжил-2022" зорилтот жилийн хүрээнд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдийн орчны аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сургалтын хөтөлбөрийг батлан шат дараатай ажлуудыг зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд ахуйн хэрэглээний газыг хяналт, хязгаарлалтгүйгээр насанд хүрээгүй хүүхдэд зарж борлуулах, түүнчлэн зарим эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналт суларснаас үүдэн өсвөр насны хүүхдүүд газ үнэртэн, мансуурч донтох, үүний улмаас амь насаа алдах эрсдэл үүсч болзошгүй тул Сайншанд сумын ЕБ-ын 1, 5 дугаар сургуулийн өсвөр насны ахлах ангийн сурагчдад ахуйн хэрэглээний газыг зориулалтын бусаар хэрэглэх байдлаас урьдчилан сэргийлэх, ахуйн газны хор хөнөөл, уршгийн талаар мэдлэг, мэдээлэл өгч шторк, видеог үзүүлэн зурагт хуудас тараан ажиллалаа.

ГХБХБГазарт "Ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 11 ажилтанд зохион байгуулж, ажлын байранд хэмжилт, шинжилгээ хийж, ажлын байрны дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

## **5. Байгууллагын дотоод ажил**

- Байгууллагын албан хаагч нарт ТАХ-н ёс зүйн дүрэм, цаг ашиглалтын талаар сургалтыг хийсэн.
- Улсын байцаагч нар сумдаар явж иргэд ААНБ-дад хууль эрхзүйн талаар сургалт мэдээлэл хийсэн талаар байгууллагын вэб сайтад мэдээлэл оруулж мэдээлж ажилласан.
- АИТХ-н Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ээлжид хуралдаанд ТЗЭУХ-н дарга оролцож мэдээлэл хийсэн.
- АЗДТГ, Мобиком корпорацийн хамтарсан Цахим хөгжлийн шийдэл танилцуулга арга хэмжээнд байгууллагын төлөөлөл оролцсон.
- Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан "Байгаль орчин, амьтан ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил"-өөс урьдчилан сэргийлэх илрүүлэх, шалган шийдвэрлэх хохирол нөхөн төлбөрийг гаргуулах хор уршгийг арилгуулах чиглэлээр тодорхой ажлыг хууль хяналтын байгууллагуудтай хамтран сарын хугацаанд тодорхой ажлуудыг зохион байгуулах уулзалт хэлэлцүүлэгт ТЗЭУХ-н дарга оролцсон.
- Хүүхдийн баярыг угтаж байгууллагын албан хаагч нарын хүүхэд эцэг, эхчүүдийн дунд гэр бүлийн эерэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

### **2.2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Тайлант хугацаанд иргэд биечлэн -2, утсаар-6, цахимаар-2 удаагийн зөвлөгөө авсан байна. Үүнээс гадна холбогдох хэлтэс, сумдад зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгч ажиллав.

Хууль тогтоомжийн өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл:

- ✓ 2022 оны 05 дугаар сард хэвлэгдсэн гарсан “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2 дугаарыг хүлээн авч, нийтлэгдсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг төрөл тус бүрээр нь нэг бүрчлэн бүртгэж лавлагаа мэдээллийн санд баяжуулалт хийж ажиллалаа.
- ✓ Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хязгаар болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдрийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн тогтоож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн, холбогдох байгууллагуудад хүргэн хэрэгжүүлж эхлээд байна.

Сумын нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх бүс тогтоох, хориглосон бүсэд орж ногоон байгууламж сүйтгэсэн малыг хашиж журамлах журмын төсөлд зөвлөмж өгөв.

### **Архивын тасаг**

Аймаг, сумдын 31 төрийн байгууллагаас хэвлэмэл хуудасны захиалгыг хүлээн авч, нийтилэг үйлчилгээний газарт эх бэлтгүүлэхээр хүргүүлсэн. Баримт бичиг.2-р хэсэг.Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага. MNS 5140-2:2021 стандартын 12 байгууллагын 6 төрлийн хэвлэмэл хуудасны эхийг хянаж хэвлэх зөвшөөрөл олгов. Хянасан хэвлэмэл хуудасны эхээр мэдээллийн сан бүрдүүлж байна.

Иргэдээс архивын лавлагаа авахыг хүссэн 85 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, 82 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа явж байна. Нийт 49 иргэнд архивын лавлагаа олгосон бөгөөд архивын лавлагааг ангилан үзвэл: Малын А данс 8 иргэнд, цалингийн тодорхойлолт 19, Иргэний гэр бүлийн лавлагаа-1, архивын тодорхойлолт 21 байна. Архивын мэдээллийн цахим сан болон цаасан суурьтай баримт шүүн үзэж 46 иргэнд архивын баримтын хуулбар 130-ыг олгосон. Нийт олгосон баримтын хуулбарын 102-ыг цахим сангаас, 28 цаасан суурьтай баримт шүүж олгосон.

Архивын тасгийн 2022 оны цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу Өргөн сумын ЗДТГ-ын 2014-2016 оны малын А дансны 10 хадгаламжийн нэгж, Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2012-2013 оны 10 хн, нийт 20 хадгаламжийн нэгжийн 3561 хуудас баримтыг EDOC программд шивж, 891 заалт 900 хүний нэр тодорхойлон бичиж мэдээллийн сан үүсгэв.

Аймгийн архивын тасгийн 2022 оны нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу Нийтлэг үйлчилгээний газар, Хөвсгөл сумын Соёлын төв, Сайншанд сумын ИТХ зэрэг 3 байгууллагаас байнга хадгалах 87 хадгаламжийн нэгж хүлээн авч, сан хөмрөгт баяжилт хийсэн.

Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй” сэдэвт сургалтад аймгаас 9 ажилтан хамрагдаж, мэргэжлийн үнэмлэхтэй болсон.

### **Улсын бүртгэлийн хэлтэс**

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр- 1509
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр- 100
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр- 841, нийт 2450 бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь энэ сард нийт 841 мэдүүлэг хүлээн авч зохих үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний хураамж 6735805 төгрөг, тэмдэгтийн хураамж 489880 төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны татварт 62122245 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

### **Цагдаагийн газар**

## **Нэг. Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц**

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс болон цагдаагийн газраас гэмт хэрэг зөрчилаас урьдчилан сэргийлэх чиглэлээр [www.Dornogobi.police.gov.mn](http://www.Dornogobi.police.gov.mn) цахим пейж хуудас болон Дорноговь цагдаа, Замын-Үүд цагдаа FACEBOOK цахим хаягт урьдчилан сэргийлэх чиглэлээр зурган постер 10 мэдээлэл, видео контент 3 тус тус иргэдэд түгээн олон хандагчтай цахим групп түгээлт хийн 38198 иргэний хандалт тус тус авсан байна.

### **Хоёр. Цаг үеийн ажлын мэдээлэл**

Тус Цагдаагийн газраас Замын-Үүд – БНХАУ-ын Эрээн хотын хилийн боомтоор чингэлэг тээврийн аюулгүй байдлыг, замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолооч нарын халдвар хамгаалаллыг хангах зорилгоор хамгаалалтанд Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчид үүрэг гүйцэтгэн ажилласан.

Цагдаагийн газраас “Хайрлаж үлгэрлэе”, “Сэрэмжлүүлье” арга хэмжээнүүдийн хүрээнд аймгийн гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар, прокурорын газартай хамтран Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2, 3 дугаар сургуулиудад хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх танхимын сургалт зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох зөв дадал эзэмшүүлэх, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Замын хөдөлгөөний цагаан толгой -2022" тэмцээнийг энэ оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, шилдгүүдийг тодруулсан.

#ХАЙРЛАЖ ҮЛГЭРЛЭЕ арга хэмжээний хүрээнд тус Цагдаагийн газраас Сайншанд сумын төвийн автобусны буудлуудад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий самбаруудыг байрлуулсан.

Амралтын өдрүүдэд тус аймгийн Хамарын хийд, Ханбаян зүрх хайрханруу аялах иргэдийн хөдөлгөөн эрс ихэссэн тул тус цагдаагийн газраас гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэг, гудамж талбайд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зам тээврийн осол хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж эргүүлийн 18 байршил нийт 34 алба хаагч 20:00 цагаас 02:00 цагийн хооронд хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулсан.

Олон Улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан Хайрлаж үлгэрлэе арга хэмжээний хүрээнд цагдаагийн газрын 5 алба хаагчийн гэрлэх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж, аз жаргал, эрүүл энхийг хүссэн.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэж шүүхээс баривчлах шийтгэл авч баривчлах байранд хүмүүжиж байгаа иргэдэд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хуваарийн дагуу зан үйлд нөлөөлөх сургалт мэдээллийг тогтмол хийсэн.

ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албанаас зохион байгуулсан “Мод тарья байглиа бүтээе” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулан ажилласанаас тус аймаг дахь цагдаагийн газар нь өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлаараа 21 аймгаас шалгарч 3 дугаар байранд шалгарсан.

Арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн газраас Сайншанд сумын 1, 6, 8 дугаар багт байрлах иргэдийн ус түгээх байр /худаг/-ны хананд аяны хүрээнд тавигдсан мэдээллийг агуулсан зургийг шинээр зуруулж иргэдэд сурталчсан. Сайншанд сумын байрлах автобусны буудлын 3 ширхэг самбарт аяны хүрээнд гаргаж бэлтгэсэн 3 төрлийн хулдаасан самбарыг байршуулан иргэдэд сурталчлан ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус цагдаагийн газрын алба хаагчид гэр бүлийн хамт ЦЕГ-аас зохион байгуулж байгаа “Мод тарья, байгалиа бүтээе” аянд нэгдэн 80 ширхэг модны суулгац тарьж, аян нэгдлээ.

Хууль Зүй, Дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан журам, Цагдаагийн Ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/03 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган цагдаагийн газрын алба хаагчдын биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэх хангах ур чадварын түвшинг дээшлүүлэх сургалт, дадлагыг 101 алба хаагчийн дунд зохион байгуулсан.

Цагдаагийн газрын биеийн тамир спортын хамтлагаас батлагдсан 2022 онд алба хаагчдын дунд зохион явуулах тэмцээн уралдааны удирдамж төлөвлөгөөний дагуу цагдаагийн газрын аварга шалгаруулах “Буудлагын” тэмцээнийг зохион байгуулан аваргуудаа тодруулав.

Улсын Онцгой комиссын орлогч даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 90 дугаартай “Чиглэл өгөх тухай” үүргийг хариуцсан нутаг дэвсгэрт хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус аймгийн Сайншанд сумын нутаг дэвсгэрт 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 07:00-18:30 цагийн хооронд “Хутагтын хурд-2022” Дорноговь аймгийн бүсийн хурдан морины уралдаан зохион байгуулагдах үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэж ажилласан. Үүнд:

Тус аймгийн Сайншанд сумын хэмжээнд насанд хүрээгүй хүүхдүүд орон сууцны дээвэрт гарч тоглох унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн газраас Сайншанд сумын нутаг дэвсгэрт байрлах орон сууцны орц хонгил дээвэрт нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулан илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр холбогдох байгууллагуудад албан мэдэгдлийг хүргүүлсэн.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар**

*Цагдан хорих байрны талаар:*

Хоригдогч, хоригдлын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэн ажиллаж үзлэг, нэгжлэгийг тогтмол хугацаанд чанартай зохион явуулан ажилласан.

Цагдан хорих байрны үйл ажиллагаа цагийн хуваарийн дагуу хэвийн явагдаж ямар нэг гэмт хэрэг, зөрчил дутагдалгүй байна.

*Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр:*

2021 оны эхний үлдэгдэл 233 гүйцэтгэх баримт бичгийн 3372662,4 төгрөгийн төлбөр дээр шинээр шүүхээс 1315412,4 төгрөгийн үнийн дүнтэй 240 гүйцэтгэх баримт бичиг, харьяаллын дагуу алба хооронд 50120,7 төгрөгийн үнийн дүнтэй 6 гүйцэтгэх баримт бичиг, түдгэлзүүлснийг сэргээсэн 129264,6 төгрөгийн үнийн дүнтэй 6 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор 373876,1 төгрөгийн үнийн дүнтэй 65 гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлж, газар хооронд 119373,5 төгрөгийн үнийн дүнтэй 8 гүйцэтгэх баримт бичиг шилжүүлж нийт гүйцэтгэвэл зохих 3882686,6 төгрөгийн үнийн дүнтэй 411 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 292995,2 төгрөгийн үнийн дүнтэй 118 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 211265,1 төгрөгийн үнийн дүнтэй 106 гүйцэтгэх баримт бичигт хэсэгчилсэн төлөлт хийж 3378426,3 төгрөгийн үнийн дүнтэй 293 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажилласан.

Тайлант хугацааны эцэст гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 28,7 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн 2021 оны эхний үлдэгдэл 309233,3 төгрөгийн үнийн дүнтэй 269 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 220135,2 төгрөгийн үнийн дүнтэй 19 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, 70,2 төгрөгийн үнийн дүнтэй 1 гүйцэтгэх баримт бичиг газар хооронд харьяаллаар шилжүүлж, гүйцэтгэвэл зохих 529298,3 төгрөгийн үнийн дүнтэй 286 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 36464,9 төгрөгийн үнийн дүнтэй 10 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 139 гүйцэтгэх баримт бичгийн 191481,1 төгрөгийг хэсэгчлэн биелүүлж, тайлант хугацааны эцэст 301352,3 төгрөгийн үнийн дүнтэй 268 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж гүйцэтгэх баримт бичиг 6,2 хувь мөнгөн дүн 43,1 хувьтай байна.

Тус газар нь 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3 иргэн 35 хуулийн этгээдэд өр төлбөргүй лавлагааг олгон ажилласан байна.

Сум хөгжүүлэх санд холбогдох гүйцэтгэх баримт бичгийн талаар:

Сайншанд суманд холбогдох 34 гүйцэтгэх баримт бичгийн 327,894,695 төгрөгийн төлбөрөөс 1 гүйцэтгэх баримт бичгийн 10,253,167 төгрөгийг бодитой биелүүлж, 43,042,328 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж 274,599,200 төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй,

Айраг суманд холбогдох 2 гүйцэтгэх баримт бичгийн 22,096,089 төгрөгийн төлбөрөөс 11,829,089 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж 10,267,000 төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй,

Даланжаргалан суманд холбогдох 2 гүйцэтгэх баримт бичгийн 22,848,356 төгрөгийн төлбөрөөс 10,170,000 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж 12,678,356 төгрөгийн үлдэгдэлтэй,

Хатанбулаг суманд холбогдох 3 гүйцэтгэх баримт бичгийн 32,180,844 төгрөгийн төлбөрөөс 15,449,784 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж 16,731,060 төгрөгийн үлдэгдэлтэй, Хөвсгөл суманд холбогдох 1 гүйцэтгэх баримт бичгийн 8,381,000 төгрөгийн төлбөрөөс 500,000 төгрөгийг хэсэгчлэн төлүүлж 7,881,000 төгрөгийн тус тус үлдэгдэлтэй болно.

### **2.3. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

“Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын лабораторийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдал” сэдэвт онол, дадлага хосолсон 2 хоногийн сургалтыг 5 сарын 19-20 ний өдрүүдэд зохион байгуулж, 14 лаборантыг хамруулав.

Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах өдөрлөгийн хүрээнд Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар 2022.05.13-14-ний өдрүүдэд Дорноговь аймагт ажиллаж, орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх, цэргийн үзлэгийн 07 -ын асуудлыг газар дээр нь шийдвэрлэх ажлыг зохион байгуулав. Мөн нэгдсэн эмнэлгийн эмч нартай хамтран 5 мэс заслын хагалгааг хийж, харилцан туршлага солилцлоо. 9 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд 326 хүн хамруулан, эмчилгээ зөвлөгөө өгсөн.

АНЭ-ийн хүний нөөцийн асуудал эрхзүйн баримт бичигт хяналт хийж мэдээлэл өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Цаашид мэргэжлийн орон тооны хуульчийг зайнаас биш ажлын байран дээр ажиллуулах шаардлагатай байна.Тусгай зөвшөөрлийн комисс хуралдаж 11 асуудал шийдвэрлэлээ. Үүнээс 1 эмнэлэг шинээр, 10 эмнэлэг сунгадав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум” мод төслийн хүрээнд “ Дорноговь аймгийн иргэдийн цэцэрлэгт хүрээлэн” -д Эрүүл мэндийн салбарын 251 албан хаагч 416 мод тарилаа. Эрүүл мэндийн газрын албан хаагчид гэр бүл хүүхдүүдийн хамт оролцож Эко орчин бүрдүүлж мод тарилцаж , хог түүсэн хөөрхөн хүүхдүүдээ байгууллагын “Гэр бүлийн зөвлөл”-өөс урамшууллаа.

“Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын уулзалт зөвлөгөөн”-ийг 05 сарын 05-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд хувийн хэвшлийн 83 эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл оролцон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудал, цаашид хэрхэн ажиллах талаар хэлэлцэн олон талт сургалт мэдээллийг авч, 2022 онд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.ХӨСҮТөвийн ТҮМ-ийн нэгжийн давхар судлаач эмч нарын баг аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн ЭМТөвд дэмжлэг хяналт хийв.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг 5/1-нд нээлтийн арга хэмжээ Аймгийн Нэгдсэн Эмнэлэг дээр зохион байгуулагдлаа 5/6-ний байдлаар Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд 0-5 насны 48 иргэн, 6-17 насны 1229 иргэн, 18-с дээш насны 248 иргэн хамрагдсан байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг сурталчлах өдөрлөг 5/6-нд аймгийн төв талбайд зохион байгуулагдаж, Өдөрлөгт Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгал, өрхийн эрүүл мэндийн төвүүд оролцож иргэдэд мэдээлэл өгч, 1578 ширхэг гарын авлага тараасан байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагуудын тарьсан модны судалгааг авч нэгтгэхээр албан бичгийг боловсруулан, бүх эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн судалгааг авч байна.

“ЭКО ХОТ-2022” зорилтот жилийн хүрээнд орчны эрүүл мэндийг сайжруулах, хог хаягдлын ангилан ялгалтын талаарх мэдлэгийг түгээж, зөв дадал төлөвшүүлэх, бүх эрүүл мэндийн байгууллагуудыг энгийн хог хаягдлаа ангилан ялгадаг хамт олон болгох зорилгоор эрүүл мэндийн салбартаа “Хог хаягдлаа ангилан ялгадаг хамт олон” аяныг эхлүүлээд явж байна.Аймгийн хэмжээнд “Талбарын тархвар судлал”-ын анхан шатны, богино хугацааны сургалтын хэрэгцээг судалж, сургалтанд хамрагдах анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийн мэдээллийг ХӨСҮТ-д хүргүүлэв.

2022.05.26, 27-ны өдрүүдэд ЭМЯ, ХӨСҮТ-өөс 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Ханги боомтод PCR-ын лаборатори байгуулах үйл ажиллагаатай танилцаж, арга зүйгээр ханган ажиллаж байна. Ханги боомт дээр ажлын хэсгийн хамт ЭМГ-ын халдвар судлаач томилогдон ажиллаж байна.

ДЭМБ-аас зөвлөмж ирүүлсний дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс “Сармагчны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Хачигт халдвараас урьдчилан сэргийлье” чиглэлээр цахим сургалт зохион байгуулж, сургалтанд ЭМГ-ын мэргэжилтнүүд болон АНЭ, ЗҮНЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хамрагдаж мэдээллээр хангагдсан2022.05.27-нд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 20 эмч мэргэжилтнүүдэд “Урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн явц, цаашид анхаарах асуудал”, “Сармагчны цэцэг өвчний талаарх мэдээлэл”, “Коронавируст халдвараас сэргийлэх, тандалт, хариу арга хэмжээ” чиглэлээр арга зүйгээр хангах танхимын сургалтыг зохион байгуулсан.

Сүрьеэгийн батлагдсан тохиолдлын хавьтлын үзлэгийг Зүүнбаян, Улаанбадрах суманд зохион байгуулсан 2022.05.22-26-ны өдрүүдэд Айраг, Даланжаргалан, Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх сумдад Эрүүл мэндийн газрын 6 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, эрүүл мэндийн байгууллагуудын тусламж

үйлчилгээ, халдвар хяналт болон бусад үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн вирус судлалын лабораторит хачигт халдварт өртсөн байх магадлалтай Сайншанд сумын болон Эрдэнэ сумын 2 хүүхдийн цусны ийлдсийг давтан шинжилгээнд хүргүүлсэн

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах нь” сэдэвт 2 хоногийн сургалтад Эрүүл мэндийн газар болон Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2 халдвар судлаач хамрагдаж, арга зүйгээр хангагдаж, бусад аймгийн халдвар судлаач нартай туршлага солилцоод ирсэн.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношлогооны ач холбогдол, мэдээ мэдээллийг хүн амын дунд сурталчлах ажлын хэсэг байнгын ажиллах “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг”-ийн багцын талаар, илрүүлэг үзлэг шинжилгээний ач холбогдлын талаарх мэдээ мэдээлэл, зөвлөмжийг өөрсдийн цахим хуудсаар тогтмол дамжуулан иргэдэд түгээж байна. Мөн ард иргэд ихээр үйлчлүүлдэг худалдаа үйлчилгээний төвүүдийн зарын самбаруудад зөвлөмж мэдээллийг байршуулсан.

### **Боловсрол, шинжлэх ухааны газар**

#### **Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

2022 оны 05 дугаар сард 14 сумын 21 сургууль, 36 цэцэрлэгийн танхимын хичээл хэвийн явагдаж 18827 сурагчид танхимаар хичээллэсэн.

БШУЯ, БЕГ, Боловсролын үнэлгээний төвөөс ирсэн удирдамж, шалгалтын сэдэв материалын дагуу 21 сургуулийн 7523 сурагчаас 2022 оны 05 сарын 23-аас эхлэн 27-ыг хооронд гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт авч дүн нэгтгэх ажил хийгдэж байна.

Сургуулийн өмнөх боловсрол болон, Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш ажилчдад боловсролын салбарт хийгдэж буй хууль, эрх зүйн орчны шинэчлэл болон төсвийн шинэчлэлийн талаар баримталж буй бодлого, шинээр батлагдсан хууль, тогтоомжийг анхан шатанд хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очироор ахлуулсан ажлын хэсэг уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 14 сумын 57 байгууллагын 263 багш, ажилчид хамрагдсан.

Дэлхийн банкны 6 хүний бүрэлдэхүүнтэй томилолтын баг “Боловсролын чанарын шинэчлэл” 5 дугаар шатны хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэлд мониторинг хийж, БШУГ, Сайншанд 1,3,5 дугаар сургуульд төсөл хэрхэн хэрэгжиж байгаа талаар 20 багштай уулзаж ярилцлага хийсэн.

“Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд хүүхэд залуучуудын оюуны хөгжлийг дэмжих зорилгоор “ШИНЭ АЛХАМ-2022” арга хэмжээг зохион байгуулж 4 сумын 10 сургуулийн 612 сурагчдад гарын авлагыг хүргэсэн.

Дорноговь аймгийн нийтийн хоолны газрын тогооч болон Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн тогооч нарын урласан хоолоор “Говийн амт-Говийн брэнд” үзэсгэлэн 2022 оны 05 дугаар сарын 21-нд Сайншанд сумын Соёмбо цогцолборт зохион байгуулсан. Үзэсгэлэнд Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Сайншанд, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумдын 30 тогооч 14 баг болж 21 төрлийн орчин үеийн Монгол хоол, эмчилгээ, сувиллын хоол, 7 төрлийн зуушаар оролцлоо.

“Хүүхэд хөгжил- 2022” зорилтот жилийн хүрээнд Сайншанд сумын 4,6,11,12,13-р цэцэрлэгүүд мэргэжил, арга зүйгээрээ нэгдэн ажиллаж “Нэг цэцэг-нэг дэлхий” мянган цэцгийн баярын тайлант үйл ажиллагаагаа авьяаслаг хүүхдүүд болон багш эцэг эхчүүдтэйгээ хамтран зохион байгуулсан. Эдгээр цэцэрлэг нь 700 гаруй хүүхдэд “Үлгэрч хүүхдүүд”, “Үндэсний бий биелгээ”, “ Равжаагийн сургаал”, хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, нутгийн яруу найрагч Л. Эрдэнэбат, хөгжмийн зохиолч Ш. Өлзийбаяр нараар “ Хутагтын хүүхдүүд” нутгийн онцлогтой цэцэрлэгийн шинэ дуу бүтээлгэж, зохиолч, эмч Х.Цэрэндорж, хөгжмийн багш Ж.Нямсүрэнгийн “Мэндийн дуу”, “Гимнастикийн дуу”, “Үдэлтийн дуу” гэсэн 3 цогц бүтээлийг хүүхдүүдэд зааж сургасан байна.

“Үндэсний бичиг үсгийн өдөр-2022” ажлын хүрээнд бага ангийн багш нарын дунд “МИНИЙ МОНГОЛ ХЭЛ БИЧИГ-2022” олимпиадыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 21 сургуулийн бага ангийн 572 багш оролцсон.Мөн бага боловсролын монгол хэлний сурлагын чанарыг ахиулах, багш нарын ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих, бусдаас суралцах мөн аймгийн нэгдсэн хөтөлбөртэй болох зорилгоор 1, 2-р ангийн монгол хэлний хичээлээр "НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР" боловсруулах уралдааныг зохион байгуулсан.Уралдаанд шалгарсан нэгж хичээлийг 21 сургуулийн 275 багшид түгээн дэлгэрүүлсэн.

Улс орон даяар 5 сарын 7-нд явагдах Монгол хэлбичгийн шалгалтын хянагч, зохион байгуулагчийн судалгааг гаргаж, шалгалтын төвийн бэлтгэл ажлыг хангав. Шалгалтад нийт 117 шалгуулагч хамрагдахаас Сайншанд сумын 1-р сургуульд 98, Замын-Үүд сумын 3-р сургууль дээр 19 шалгуулагч шалгалт өгнө. Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар Бага дунд боловсролын маягт шинэчлэх ажлын хэсэгт статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн орсны дагуу маягтын шинэ загвар, маягт нөхөх заавар зэргийг боловсруулан саналаа БШУЯ-д хүргэж ажилласан.

Сайхандулаан, Мандах, Даланжаргалан, Айраг сумдын цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаатай танилцан багш нарын сургалтын хөтөлбөр, хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ, ажиглалт тэмдэглэл болон бусад бичиг баримтыг үзэж зөвлөн туслах чиглэлээр ажилласан. БШУЯ-аас хэрэгжүүлж буй цэцэрлэгийн удирдах ажилтны менежмент манлайлал, сургалтын технологийн мэдлэг чадварыг хөгжүүлэх зорилгоор “Цэцэрлэгийн менежмент, манлайлал” цахим сургалтыг 33 цэцэрлэгийн эрхлэгч болон БШУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн нарт явуулж шалгалтыг өгсөн.

Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3 сургууль, төрийн өмчит 10 цэцэрлэгт боловсролын газрын дарга, СӨБ хариуцсан мэргэжилтэн, бага боловсрол, түүх нийгмийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтэн нар очиж ёс зүйн жилийн хүрээнд зохион байгуулсан ажил, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, сурагчдын хичээл сурлагын хоцрогдол арилгах, хичээлийн төлөвлөгөө зэргийг биечлэн үзэж, шалган зөвлөгөө өгч 2 хоног ажиллалаа

“Зорилгын хүч-3” арга хэмжээг 4 сумын 10 сургуулийн 22 бүлгийн 612 сурагчдын дунд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд “Сорил-1,2”-г 10 судлагдахуунаар авч дүн мэдээг онооны жагсаалт, даалгавар бүрийн анализ, анги бүрээр гарган 12 жилийн сургуулиудад хүргүүлсэн. Сорилгод давхардсан тоогоор 1369 сурагч хамрагдаж 54,2%-н гүйцэтгэлтэй шалгагдаж “Сорил-1”-ээс 4%-иар ахисан. Тус арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчид болон Математик, Физикийн багш нарт сургалт,12 дугаар ангийн сурагчдад Математикийн хичээлээр “Дэвжээ” тэмцээн зохион байгуулж 120 сурагч 30 багш хамруулсан.



“Санаачилгатай эртэч хүүхэд” аяныг зохион байгуулж өглөөний давтлагад 12-р ангийн 2473 сурагч хамрагдахаас 2197 сурагч хамрагдаж 88,8% ирцтэй байна.

Англи хэлний хичээлээр Элсэлтийн Ерөнхий Шалгалт өгөх сурагчдын тест дээр ажиллах ур чадварыг ахиулах, хоцрогдлыг тогтоох, нөхөх, сурсан мэдсэнийг бататгах, улмаар ЭЕШ-д амжилттай дүн үзүүлэх, багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор англи хэлний сургалтыг зөвлөх багш Ч.Дэлгэрмөрөнтэй хамтран зохион байгууллаа. Тус сургалтад 20 сургуулийн 230 сурагч, 15 багш хамрагдаж тест дээр ажиллах хялбар арга техник, текст-эх дээр ажиллах аргачлалыг эзэмшсэн.

БШУЯ-аас “Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь” цахим сургалтад аймгийн төвийн сургуулиудыг хамруулж 4 багш нийгмийн ажилтан хамрагдсан.

Хаан банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах сурагчдыг шалгаруулахад хамтран ажилласан. Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн захирлын ажлыг хүлээлцсэн.

Тайлант сарын хугацаанд агентлаг, яамнаас зохион байгуулсан цахим болон танхим хосолсон 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 110 гаруй багш ажилтныг хамруулж ажлын байран дээр нь сургаж арга зүйг дээшлүүлсэн.

#### **Цаг үеийн ажлын мэдээлэл:**

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/279 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж Хөвсгөл, Мандах сумын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт тавьж ажилласан.

Мобиком Корпорациас санаачлан хэрэгжүүлж буй “Smart Education 2” төслийн уралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрийн хооронд нээлттэйгээр зохион байгуулсан. Тус уралдаанд 14 сумын 19 сургуулийн 501 суралцагч бүтээлээ ирүүлснээс, шалгарсан 70 сурагчдад ухаалаг систем бүхий гар утас гардуулсан

“Бүх төрлийн тамхи, түүнтэй ижил төстэй бүтээгдэхүүний хор уршиг” сэдэвт цахим сургалтад 20 сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч нар /нийт 40 хүн/ хамрагдав.”Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор уршиг” сэдэвт цахим сургалтад 7-12-р ангийн нийт 1000 сурагч хамрагдав.

21 сургуульд 1721 ширхэг Сурагчийн хувийн хэргийг хүргэсэн. Байгууллагын жижүүрийн өрөө, амралтын өрөө болон хүүхэд саатуулах өрөөг тохижууллаа. Мөн номын санд байгаа номуудын эмх цэгцийг сайжруулж тавиурт өрж байршууллаа

#### **Соёл, урлаг, биеийн тамир, спортын салбар**

1. Соёлын талаар төрөөс баримтлах бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийн үзэл баримтлалын дагуу Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн үлдээх зорилгоор аймгийн Засаг даргын ивээл дор “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн анхдугаар үзлэг, наадмыг 2022 оны 05 дугаар сарын 17, 18-ны өдөр зохион байгуулсан. Үзлэг, наадамд 14 сумын 372 өвлөн уламжлагч оролцож, долоон ай савын хүрээнд ай сав бүрээс 3, нийт 21 шилдэг өвлөн уламжлагчийг шалгаруулсан бөгөөд нийт дүнгээр тэргүүн байранд Дэлгэрэх сум, дэд байранд Замын-Үүд сум, гутгаар байранд Эрдэнэ сум, тусгай байранд Сайншанд сум шалгарлаа.

2. Засгийн газрын 2019 оны “Чингис хаан музей байгуулах тухай” 280 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/300 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан, Музей сургалт, судалгааны төвийн сан хөмрөгт хадгалагдаж буй жагсаалтад орсон 15 дэсийн 21 ширхэг үзмэрийг Соёлын өвийн үндэсний төв болон Чингис хааны музейн хамтарсан ажлын хэсэгт түр шилжүүлэх акт үйлдэн хүлээлгэн өгсөн.
3. Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 6в ангийн 30 сурагчид Түүхийн хичээлийн хүрээнд “Зэр зэвсэг” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
4. Зураач, барималч Б.Үлэмжбатын 70 гаруй уран бүтээлээс бүрдсэн “Үлэмжийн чанар” уран зургийн үзэсгэлэнг аймгийн МССТ-д дэлгэн, 100 гаруй хүн үзэж сонирхлоо.
5. МССТ-ийн үзүүлэгийн 5-р танхимд Дэчинчойнхорлин хийдийн ламын номын гэрийг барьж үзүүлэлэг дэглэсэн. Мөн социализмын үе буюу 1970-1990 он хүртэлх аж амьдралын харуулсан булан үүсгэн байгуулж үзүүлэгийн танхимаар 2022 оны 05 дугаар сард 793 хүүхэд, 13 гадаадын иргэн, 114 насанд хүрэгчид тус тус үйлчлүүлсэн байна.
6. Саран хөхөө театрын “Театрт тавтай морил” аяны хүрээнд Монгол Улсын Хүүхэлдэйн театраас албан ёсны эрхтэйгээр “Могжоохон даагатай Жогжоохон хүү” хүүхэлдэйн жүжгийг аймгийн хэмжээнд нийт 1486 хүүхэд багачуудад тоглож, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн 50 хүүхдийг үнэ хамруулсан.
7. “Саран хөхөө” театрын дэргэдэх “Авьяс” хүүхдийн дугуйлан 7 хоногт 2 удаа тогтмол хичээллэж байна. Морин хуур, драм, бүжгийн дугуйланд 59 хүүхэд хамрагдаж байна.
8. Төв номын сангийн танхимаар шинээр 138 уншигч, 2433 ирцэд 1859 ном олгож үйлчилсэн байна. Сэдэвчилсэн лавлагааг 15 удаа өгч уншигчдын хэрэгцээт ном зохиолыг түргэн шуурхай эрэлт хийж ажилласан. “Дорноговь Төв номын сан” пэйж хуудсаар “НОМТОЙ ДОРНОГОВЬ” аяны хүрээнд зохиол бүтээл, танин мэдэхүйн мэдээ мэдээлэл, онч сургаал, үндэсний болон бусад хэл, бичиг соёлыг таниулах зэрэг ажлыг цахимаар нийт 6949 хүнд хүргэсэн байна.
9. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Илүүдэл жингүй эртэч Монгол” аяны өглөөний дасгалыг 7 хоног бүрийн Даваа-Баасан гарагуудад 06.30-07.30-ын хооронд Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолбор, Спортын ордонд шууд дамжуулан тогтмол явуулж, 2022 оны 5 сарын байдлаар Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Хаан банк, БШУГазар, БОАЖГазар, ГХБХБГазрын хамт олон хамрагдаж, идэвхитэй оролцсон иргэн, аж ахуй нэгж, байгууллага, сумдыг шагнаж урамшууллаа.
10. Монголын бүх ард түмний спортын XV наадмын Зүүн бүсийн “Сагсан бөмбөг”-ийн тэмцээн Спорт цогцолборт 05 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Говьсүмбэр аймгийн баг, тамирчид оролцож, Дорнод аймгийн баг тэргүүн байранд шалгарсан байна.
11. Чөлөөт бөхийн залуучуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 05 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд болсон.
12. Залуучуудын сагсан бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээн 30 жилийн дараа Дорноговь аймгийн Сайншанд суманд 05 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд Спорт цогцолборт амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 16 багийн 200 гаруй тамирчид оролцож, эрэгтэйчүүдийн төрөлд “Этүгэн Ирвэсүүд” баг тэргүүн байр, “Баянхонгор” баг дэд байр, “Хэтбат ХҮИС wolves” баг гутгаар байр, эмэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байранд “Дорноговь Зүүнбаян” баг, дэд байранд “Этүгэн ирвэсүүд”

баг, гутгаар байранд "Хэтбат ХҮИС wolves" баг тус тус шалгарсан. Эрэгтэй "Шилдэг тоглогч"-оор "Этүгэн ирвэсүүд" багийн тамирчин н.Гарьд, Эмэгтэй "Шилдэг тоглогч"-оор "Дорноговь Зүүнбаян" багийн тамирчин н.Нацагдулам, "Шилдэг дасгалжуулагч"-аар ХҮИС-ийн дасгалжуулагч н.Мөнхтүвшин нар шалгарсан байна.

13. Дэлхийн улс орнуудад энх тайван, амар амгаланг уриалах зорилгоор зорилго бүхий "Галт бамбар буухиачлах" гүйлтийг Монголын Шри Чинмойн марафоны багаас 05 дугаар сарын 14-нөөс 07 дугаар сарын 07-ны өдрийн хооронд 108 хоногийн турш "Шри Чинмойн Эвийн өргөө-Энхийн гүйлт 2022" арга хэмжээ 21 аймгийн 108 сумын 7250 км замд зохион байгуулагдаж байна. Энэхүү гүйлт Дорноговь аймгийн Дэлгэрэх, Алтанширээ, Сайншанд, Айраг, Даланжаргалан сумдаар дайран өнгөрсөн. Сайншанд суманд 05 дугаар сарын 26-ны өдөр "Галт бамбар"-ыг хүлээн авах ёслолын ажиллагаа зохион байгуулагдлаа.

### ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

Үйлчилгээ	Тоо хэмжээ
Шинэ ажлын байрны тоо:	26 буюу өмнөх оны мөн үеийнхээс 17-оор буурсан байна
Ажилд зуучлагдсан иргэдийн тоо:	109 буюу өмнөх оны мөн үеийнхээс 39-аар өссөн.
Ажлын байрны захиалгын тоо:	150 буюу өмнөх оны мөн үеийнхээс 61-ээр өссөн байна.
Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо:	239 буюу өмнөх оны мөн үеийнхээс 75-аар буурсан.

#### А. Зохион байгуулсан арга хэмжээ

##### Нэг. Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

1. Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй иргэдийг 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрийг дуустал бүртгэж, төслийг 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 17-ны өдрийг дуустал хүлээн авсан. Тус хугацаанд Ахмад-37, Хөгжлийн брэхшээлтэй иргэд-27, Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр-36, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр-1 иргэн, нийт 101 иргэн төслөө ирүүлснээс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж анхан шатны сонгон шалгаруулалтаар 13 иргэний 120.0 сая төгрөгний төслийг дэмжиж, ажлын байртай танилцахаар шийдвэрлээд байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн "Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ"-ний төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж төсөл ирүүлсэн 1 иргэнийг дэмжихээр шийдвэрлэлээ. Бусад ажлын хэсгийг 6 сарын 03-ны дотор хуралдахаар төлөвлөөд байна.

Санхүүгийн дэмжлэгт төсөл ирүүлсэн ахмадыг сумдаар харуулвал Сайншанд-12, Иххэт-4, Эрдэнэ-2, Айраг-3, Даланжаргал-4, Улаанбадрах-1, Замын-Үүд-6, Мандах-2, Өргөн-3, ХБИ-ийн хувьд Сайншанд-8, Иххэт-6, Айраг-2, Замын-Үүд-4, Өргөн-5, Хатанбулаг, Даланжаргалан тус тус 1 байна.

Мөн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрийг дуустал Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Старт-Ап арга хэмжээнд оролцох хүсэлтэй иргэд, 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 16-ны өдрийг дуустал

жижиг зээлд хамрагдах хүсэлтэй иргэдийн бүртгэлийг зарлаж, Старт-Ап арга хэмжээнд 9, жижиг зээлд 12 иргэнийг бүртгэж, жижиг зээлд бүртгүүлсэн иргэдэд зээлийн өмнөх сургалтыг 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар бүртгүүлсэн нийт 64 иргэнд зээлийн өмнөх сургалтыг цахим болон танхимаар Хөгжлийн шийдэл сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан.

3. Ногоон ажлын байр хөтөлбөрийн “Нийтийг хамарсан ажил зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд 10 сумаас 13 төсөл ирснийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, 7 сумын 7 төслийг 65 иргэн, “Мод тарих” арга хэмжээний хүрээнд 14 суманд 500 иргэнийг түр ажлын байраар хангахаар шийдвэрлээд байна.

4. “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн “Малчдыг малжуулах арга хэмжээ”-нд хамрагдах шаардлага хангасан өрх болон гэрээт малчин авч ажиллуулах сонирхолтой 600-аас дээш малтай ажил олгогч малчин өрхийн судалгааг гарган, гэрээт малчин өрхөөр ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх зар мэдээллийг байгууллагын пэйж хуудсаар түгээн ажилласан.

“Малчдыг малжуулах” арга хэмжээнд 8 сумын 19 өрхийн төсөл ирснээс төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлаар 8 сумын 17 өрхийг малжуулахаар дэмжээд байна. Сумдаар харуулбал Айраг сум-1, Даланжаргалан сум-1, Мандах сум-4, Замын-Үүд сум-2, Хатанбулаг сум-2, Хөвсгөл сум-1, Өргөн сум-3, Сайншанд сум-3 өрх байна.

5. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтыг Дарь-овооны эзэд ТББ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран зорилтот бүлгийн /ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүд, ажил хайгч/ 178 иргэнд зохион байгууллаа. Сургалтад Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ, Өргөн, Дэлгэрэх, Иххэт сумдын иргэдийг хамруулан ажилласан.

#### **Хоёр. Нийтлэг үйлчилгээний хүрээнд:**

1. **Ажил хайгч:** Нийт 10 иргэнийг ажил хайгчаар шинээр бүртгэн, 12 иргэнийг /шилжсэн, ажилд орсон, өөрийн хүсэлтээр зэрэг шалтгаанаар/ бүртгэлээс хасан, ажилгүйдлийн тодорхойлолт 38 хүнд гаргаж ажиллалаа.

2. **Ажлын байрны захиалга, түүний зар мэдээ:** Тайлант сард 12 ААНБ-аас 18 ажлын байрны захиалга авч, ажлын байрны зарыг DTV телевиз, 89.1 FM, ХХҮГазрын вэйб хуудас, ажил хайгч иргэдийн нэгдсэн группд байршуулан, тохирох мэргэжлийн ажил хайгч иргэд рүү утсаар холбогдон санал тавьж сонирхсон иргэдийн анкетыг хүлээн авч ажилласан.

3. **Ажилд зуучлах үйлчилгээ:** МАК цемент ХХК-д 23, Сод монгол ШТГ -10, Хөх бишрэлт ХХК-12 иргэн, нийт 45 иргэнийг ажилд зуучлалаа.

4. **Хамтран ажиллах гэрээ:** Тендерт оролцох хүсэлтэй Болор-Аграмба ХХК /№30/, Төгс-Өнөд ХХК /№31/, Жи жи ай ХХК /32/, Мандах наран сүлжээ /33/, Хан баян буурал чандмань ХХК /34/-тай “Хамтран ажиллах” гэрээ байгууллаа.

5. **Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ:** Тайлант сард Хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 25 иргэнд, Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 32 сурагчид ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.

5 сарын 16-20-ны өдрүүдэд ЕБС-ын сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөөг Улаанбаатар хотын Дарь овооны эзэд ТББ-ын дэргэдэх сургалтын

байгууллагатай хамтран зохион байгууллаа. Үүнд: Замын-Үүд-320, Эрдэнэ-40, Өргөн-50, Дэлгэрэх-53, Иххэт-55, Даланжаргалан-43 сурагчид хамрагдлаа.

**Гурав. Бусад үйл ажиллагааны хүрээнд:**

1. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 101 иргэнд профайлинг судалгааг хийсэн.

2. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөл: 2022.05.16-26-ны хооронд бүртгэлийн ажил хийгдэж байгаатай холбоотойгоор олон нийтэд сурталчилах мэдээ мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулан ажиллав. Байгууллагын пэйж хуудас болон Ажил хайгч иргэдийн нэгдсэн группээр зар мэдээлэл, Залуучуудын хөгжлийн төв Дорноговь пэйж хуудсаар шууд нэвтрүүлэг, бусад цахим хуудас, DTV телевизээр шторк богино хэмжээний бичлэг цацан зарлан мэдээлж, гарын авлага тарааж, зурагт хуудсыг 13 худалдаа үйлчилгээний газарт байршуулан, 05 сарын 25-нд Сайншанд сумын бүх багуудын багийн ажлын алба, иргэдэд, Шинэ зуун үйлчилгээний төв, Номин худалдааны төвд ажиллан иргэдэд мэдээлэл, бүртгүүлэх заавар өгч ажиллалаа. 25-26-ны өдөр www.E-Mongolia.mn цахим системд иргэдийг бүртгэж ажилласан. Үүнд: Төмөр замын богино хэмжээний сургалтанд хамрагдсан 90 залуучуудаас 50 сурагч бүртгүүлж, 21 залуучууд 17 настай, нийгмийн даатгал төлсөн, 2021 онд хамрагдсан, бага насны хүүхэдтэй шалтгаанаар хасагдав. Эдгээрээс гадна мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 60 гаруй иргэд бүртгүүлсэн байна.

3. 2021 оны Оролцоо төслийн 1, 2-р ээлжинд хамрагдсан М.Хүрэлцоож /Цагдаа/, Б.Оюундарь /Онцгой байдлын газар/, О.Хулан /13-р цэцэрлэг/, Ц.Лхагвасүрэн /Fashion color хувцас захиалга/нарын богино хэмжээний танилцуулга бичлэгийг DTV телевизтэй хамтран хийж ХХҮЕГ газарт хүргүүлэв.

4. Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газарт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендерийг нээсэн.Тендерт нэгч аж ахуйн нэгж үнийн санал ирүүлээгүй тул дахин ажлын 7 хоногийн хугацаатай тендерийг зарласан. Тендертэй холбоотой бичгээр 1, утсаар 1 гомдол ирсэнг үнэлгээний хорооны нийт бүрэлдэхүүнд танилцуулан аж ахуй нэгжүүдэд хариуг утсаар өгч ажилласан.

5. Мэргэжил сурталчлах Өдөрлөг арга хэмжээг 5 сарын 09-нд Политехник коллежтэй хамтран, ЕБ-ын сургуулийн 4-н сургуулийн 9 дүгээр ангийн 6 бүлгийн 300 гаруй төгсөгчдөд мэргэжил сонголтын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

6. Сайншанд сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 1, 2, 3, 5 дугаар сургуулийн 12 дугаар ангийн 387 сурагчдад Мэргэжлээ зөв сонгох нь өөрийн болон улс орны ирээдүйн хөгжил, карьер төлөвлөлтөд эерэгээр нөлөөлөх гол хүчин зүйлсийн талаар сургалтыг зохион байгуулан ажилласан.

7. Дорноговь аймгийн Анагаах ухааны сургуулийг 2022 оны хичээлийн жилд 5 мэргэжлээр төгсөх ангийн 100 гаруй оюутнуудад ажлын байрны танилцуулга, Ажлын ярилцлагад ороход анхаарах асуудал, 2020-2023 оны хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааны талаар мэдээлэл хийж, гарын авлагыг өгч ажилласан.

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулж, сарын аяны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

**Дөрөв. Төсөв, санхүүгийн хүрээнд:**

**1. Тайлан мэдээ санхүүгийн бүртгэл**

а) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 05 сарын мэдээг Шилэн дансанд сар бүр оруулах 3 /өссөн дүнгээр 15/ мэдээ, тухай бүр оруулах 8 /өссөн дүнгээр 40/ мэдээ, хуулийн хугацаанд байршуулсан.

b) Төсвийн гүйцэтгэлийн 4 сарын мэдээг гаргаж ХХҮЕГазарт хүргүүлсэн.

с) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 100060037010 тоот дансанд 2022 оны 05 сарын 01-нээс 25-ны өдөр хүртэл нийт 63 иргэнээс 42,309,340 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт төлөгдснийг санхүүгийн программд бүртгэж ажиллалаа.

Насжилтаар: Хугацаандаа байгаа авлагын эргэн төлөлт 54 иргэний 24,153,340 төгрөг, хугацаа хэтэрсэн авлагын эргэн төлөлт 9 иргэний 18,156,000 төгрөг байгаагаас 100,000 төгрөг нь ШШГАлбаар шийдвэрлүүлсэн болно. Зээлийн авлага бүрэн барагдуулсан 6 иргэн нийт 15,056,000 төгрөг.

Хөтөлбөрөөр:

## **2. Авлага барагдуулах ажил**

a) 2018 оны санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн нийт 32 иргэний 133,948,000 төгрөгийн авлагаас нийт 12 иргэний 21,137,500 төгрөгийн зээлийн материалыг шүүхэд өгсөн. 3 иргэн зээлийн төлбөр нийт 6,700,000 төгрөгийг төлж, 8 иргэн 2022.06.05-нд зээлээ төлөхөөр тохиролцсон тул шүүхэд өгөөгүй болно. 9 иргэний материалыг 2022.09 сард өгөхөөр төлөвлөж байна.

b) Малжуулах санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг барагдуулахаар нийт 18 иргэнтэй холбогдсон: 14 иргэн нийт 21,330,000 төгрөгийн эргэн төлөлт хийгдснээс 5 иргэн зээлээ бүрэн барагдуулж нийт 9,600,000 төгрөгийн авлага хаасан.

## **3. Цаг үеийн ажил**

a) ХХҮЕГазарт Төсвийн хязгаарын санал хийж хүргүүлсэн

b) Сангийн яамтай тооцоо нийлэх тооцооны үлдэгдлийн баталгаа гаргаж ХХҮЕГазарт хүргүүлсэн. Нийт 12 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН**

✓ ХХҮГазрын санхүүгийн ил тод байдлын самбарт 2022 оны сарын гүйцэтгэлийн мэдээ, зарцуулалтын эрх хүсэлт баталгааг шинэчлэн оруулж, шилэн дансанд 34 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан.

✓ И халамж нэгдсэн системээр халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргасан 206 иргэний хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн.

✓ Халамжийн үйлчилгээг цахим системд үе шаттай шилжүүлж байгаа бөгөөд 2022 оны 04 дүгээр сараас эхлэн ахмад настанд үзүүлж байгаа хөнгөлөлт тусламжийн үйлчилгээний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч эхэлсэн.

✓ Нийгмийн халамжийн сангаас 4-р сарын тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг иргэдийн дансруу илгээж ажилласан. Үүнд:

- Цалинтай ээжийн тэтгэмж 2998 иргэнд 145,8 сая төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 522 иргэнд 18,9 сая төгрөг
- Өндөр настны тэтгэвэр 136 иргэнд 41,0 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 780 иргэнд 212,1 сая төгрөг
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр 395 иргэнд 113,9 сая төгрөг
- Асаргааны тэтгэмжүүд 1080 иргэнд 96,4 сая төгрөг
- Байнгын асаргаа шаардлагатай 253 хүүхдэд 75,6 сая төгрөг
- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй 62 иргэнд нөхөн олголтоор 1,2 сая төгрөг

- 0-18 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж 10 иргэнд нөхөн олголтоор 1,6 сая төгрөг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 81 ахмадад 16,5 сая
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж 98 иргэнд 6,0 сая төгрөг
- Онцгой тохиолдлын тэтгэмж 1 иргэнд 1,2 сая төгрөг нийт давхардсан тоогоор 6416 иргэнд 730,2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж
- Хүүхдийн мөнгө 25986 хүүхдийн 2,598.6 сая төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 258 өрхийн 569 том хүн, 694 хүүхдэд 14,6 сая төгрөг тус тус олгосон байна.

## **ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН СУДАЛГАА, ӨРГӨДӨЛ**

✓ Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 5 өргөдөл хүлээн авч, 5 өрхөөс судалгаа авч програмд шивж ХХҮЕГ-т илгээсэн.

✓ 03 дугаар сард судалгаа авсан өрхөөс мэдээлэл зөрүүтэйн улмаас өрхийн оноо бодогдоогүй 9 өрхийн мэдээллийг дахин тулган баталгаажуулж ХХҮЕГ-т илгээсэн.

## **ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ**

✓ ХБХЭМБНХСК-ын хурлаар оруулж хэлэлцүүлэх байнгын асаргаатай 17 хүүхдийн материалыг хүлээж хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнээс 3 хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай болохыг шинээр тодорхойлж, 12 хүүхдийн байнгын асаргаа шаардлагатай хугацааг сунгаж, 1 хүүхдийн асаргааг цуцалж 1 хүүхдийг оношийн үндэслэл тодорхойгүй шалтгаанаар буцаасан. Ингэснээр аймгийн хэмжээнд 247 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

✓ ОНОТХҮ-ний бүлгийн төслийн эхний ээлжийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 бүлгийн төслийн гишүүдтэй гэрээг байгуулж төслийн санхүүжилтийг олгон үйл ажиллагааг эхлүүлээд байна. Мөн үлдэгдэл санхүүжилтэнд бүлгийн төсөл хүлээн авах хугацааг ажлын хэсгээр хуралдан сунгаж зар мэдээллийг шинэчлэн DTV телевизийн зарын цаг, ДГХХҮГ дундын группээр дамжуулан сумдын мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгсний дагуу иргэд болон сумдын мэргэжилтнүүдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллан шаардлага хангасан 5 төслийг хугацаанд нь хүлээж авсан.

✓ ОНОТХҮ-ний ахмадын өдрийн үйлчилгээ үзүүлэх Аймгийн ахмадын хороо ТББ-тай хамтран ажиллах гэрээг байгуулж 1 дүгээр ээлжийн 32 ахмадыг үйлчилгээнд хамруулж эхлээд байна. DTV телевизийн мэдээний цагт тус үйлчилгээтэй холбоотой мэдээллийг бэлтгэн өгүүлсэн.

✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээр дамжуулан “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн талаарх судалгаа”-г түүвэр судалгаагаар хийж байгаа ба уг судалгаанд манай аймгийн 24 иргэн орсон байна. Дээрх иргэдийн мэдээллийг тус институтэд цахимаар хүргүүлэв.

✓ Олон улсын Holtinternational байгууллага нь тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа СӨБ-ын байгууллагын багш ажилчид болон тусгай хэрэгцээт цэцэрлэг сургуулийн бүлгийн багш нар, ХБХүүхдийн өдөр өнжүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-ийн ажилтнууд, байнгын асаргаатай хүүхдүүдийн эцэг эхчүүдэд 03 сарын 30,31-ний өдрүүдэд сургалт зохион байгуулсан. Тус сургалтаар хүүхдийн өсөлт хөгжлийг хэрхэн хянах, хооллох бэрхшээлтэй хүүхдүүдэд өдөр тутмын хоолыг яаж бэлтгэж хэрхэн хооллох талаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгааг хэрхэн хийх талаар мэдлэг мэдээллийг олгож арга зүйгээр хангасан. Тус сургалтанд холбогдох мэргэжилтнүүдээс гадна 15 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийг хамруулсан.

✓ АНУ-ын Holt international компанийн хэрэгжүүлдэг төсөлд орон нутгийн зорилтот иргэдийг хамруулахаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай

өрхийн гишүүн иргэдээс олон хүүхэдтэй өрх болон, байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй нийт 73 өрхийн судалгааг хүргүүлэв.

✓ ХНХЯамны ХБХЭМБНХТөв комисст 2019-2021 онд хурлаар орсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгааг гарган нэгтгэж илгээсэн. Эдгээр онуудад нийт давхардсан тоогоор 563 хүүхдийг тус хурлаар оруулж хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг шийдвэрлэсэн байна.

✓ ФХВ Дорноговь хөтөлбөрт хамруулахаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэний мэдээллийг ӨМНС-ийн судалгааны мэдээлэлд үндэслэн 93 өрхийг сонгон авсан. ФХВ Дорноговь салбарын ажилчидтай хамтран 46 өрхтэй нэг бүрчлэн уулзалт зохион байгуулсан. Өрхийн хөгжих сонирхол идэвхээс шалтгаалан нөхцөл байдлын үнэлгээ хийж өрхүүдээ сонгоно.

✓ ХХҮГ-ын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүлжин хөгжих төвийн үйл ажиллагааг эхлүүлэхээр эмч, багш нарыг ажлын байранд дадлагажуулахаар 11-р цэцэрлэгт туршлага судлуулсан. Одоогоор тус төвд хамрагдах хүсэлтэй 3 хүүхэд бүртгүүлсэн байна.

### **ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

✓ ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт өгсөн 9 өрхийн мэдээллийг Сайншанд болон Замын үүдийн Амьжиргааг дэмжих зөвлөлд хэлэлцүүлэхээр цахимаар хүргүүлээ.

✓ ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай боловч ажил эрхлэхгүй байгаа 3 иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөнд хамруулж, ажил хайгчаар бүртгүүлсэн бөгөөд 8 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.

✓ Тус үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай боловч ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа 130 иргэн байгаа бөгөөд эдгээр иргэдэд ганцаарчилсан сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөж, судалгаа мэдээллийг төрөлжүүлж нэгтгэж байна.

✓ Улсын хэмжээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг эхлэхтэй холбогдуулан хүсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг иргэдийн судалгааг насны бүлгээр ангилан ЭМД-ын шимтгэл төлөгдсөн эсэх, мөн эдгээр иргэдийг үзлэгт нэгдсэн журмаар хамруулах боломж байгаа эсэх талдаар ЭМГ болон ЭМД-ын хэлтэст хандахаар бэлтгэж байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар**

**Нэг. Өсвөр үе, хүүхдийн хөгжил, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

**Илтгэх урлагийн тэмцээн зохион байгуулах:** Сурагчдын уран илтгэх хэл ярианы чадвар, өөртөө итгэх итгэл, харилцааны соёлыг нэмэгдүүлэх, нийгэмд сурагчдын дуу хоолойг хүргэн, оюунлаг иргэдийг бий болгох зорилгоор “Оюуны давлагаа V” уран илтгэлийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд Ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчид болон политехник коллежийн оюутнуудын оролцсон. Илтгэх урлагийн тэмцээнд нийт 18 хүүхэд бүртгүүлж өв сайхан найруулах аргуудыг өргөн ашиглаж, үгийг амилуулан оролцож эхний 3 байр шалгаруулж шагнаж урамшуулав. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Зардал гаргах тухай А/53 дугаар тушаалаар тэмцээний шагналд шаардагдах 147250 төгрөгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гарган зарцуулав. 1-р байранд Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 126 ангийн сурагч Б.Батцэцэг, 2-р байранд Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 11а ангийн сурагч Б.Ануцэцэн, 3 дугаар байранд Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагч Д.Анужин нар шалгарсан.



**"Замын хөдөлгөөний Цагаан толгой-2022" тэмцээнийг зохион байгуулах:** "Замын хөдөлгөөний Цагаан толгой-2022" тэмцээнийг Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхдүүдийн дунд хүүхдийг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний мэдлэг олгох, замын хөдөлгөөний соёлыг түгээх зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Хүүхдийн ордонд зохион байгуулсан. Тус тэмцээнд нийт 32 хүүхэд, 8 эцэг, эхийн төлөөлөл, 4 баг оролцож, 11 төрлөөр өрсөлдөж авхаалж самбаагаа уралдуулав. Мөн Замын-үүд сумын хэмжээнд "Хүүхдийн эрх", аяны хүрээнд ЗДТГ, СД-ын прокурорын байгууллага, Цагдаагийн хэлтэстэй хамтран төрийн байгууллагуудыг оролцоог нэмэгдүүлж "Ногоон гэрэл-цагаан шугам", "АХА", "Дардас" зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж, сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Хүүхэд оролцооны байгууллагыг идэвхжүүлж, сурталчилж ажиллах:** Хүүхэд хөгжил-2022 зорилтот жилийн нээлтэд хүүхдийн оролцооны байгууллага, клуб, дугуйлангийн сурагчдыг хамруулж Хүүхдийн ордны дэргэдэх илтгэх урлаг, охид клуб, сайн дурын ач холбогдлын мэдээллийг хүргэж шинэ элсэлтийг авч ажилласан. Нийт 58 сурагч бүртгүүлээ.

**Гэр бүлийн зөвлөгөөн зохион байгуулах:** "Гэр бүлийн аз жаргалын үнэ цэнэ" зөвлөгөөнийг Монголын эмэгтэйчүүдийн холбооны Дорноговь аймаг дахь салбар, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Дорноговь аймаг дахь салбаруудтай хамтран "Гэр бүлийн гишүүдийг хөгжин дэвших нөхцөлөөр хангах, хоорондын харилцааг сайжруулах, үүрэг хуваарилалтыг шударга тогтоох, аливаа хэлбэрийн эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр бүлд бие биенээ тэвчих, уучлах байдлыг нэмэгдүүлэх, асуудал бэрхшээлийг амжилттайгаар шийдэхэд нөлөөлөх" зорилтын хүрээнд өрх гэр бүлд чиглэсэн уриалгыг гаргахаар зорилго дэвшүүлэн зохион байгууллаа. Зөвлөгөөнийг Айраг, Өргөн, Эрдэнэ, Замын-үүд, Сайншанд зэрэг 9 сумд, ОБГ, БТСГ, ГБХЗХГ зэрэг байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн төлөөллүүд, Сайншанд сумын төлөөллөөс бүрдсэн нас насны 19 гэр бүлийн 38 оролцогчтойгоо зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр: Сэтгэл зүйч М.Буянцэцэгийн лекц, ахмад буурлуудын оролцсон "амьдралын түүх" нэвтрүүлэг, оролцогчдыг хамруулсан хөгжөөнт тэмцээн, багийн ажиллагаа, хэлэлцүүлэг зэргийг зохион байгууллаа.

**Үр хүүхдээ эсэн мэнд бойжуулж нийгэмд нэр төртэй иргэн бэлтгэж өсгөсөн гэр бүлийн туршлагыг төрийн бус байгууллагуудтай хамтран нийтэд сурталчлан алдаршуулах ажлыг зохион байгуулах дэмжих:** Орон нутгийн DSB телевизтэй хамтран үр хүүхдээ эсэн мэнд бойжуулж, нийгэмд нэр төртэй иргэн бэлтгэж өсгөсөн 3 гэр бүлийн туршлагыг иргэд олон нийтэд түгээд дэлгэрүүлэх зорилгоор "Амьдралын түүх" нэвтрүүлгийг бэлтгэн "Гэр бүлийн аз жаргалын үнэ цэнэ" зөвлөгөөнд оролцогч нарт үзүүлсэн. Мөн зөвлөгөөний үеэр нас насны 10 гэр бүлийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулсан.

**Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, өвлүүлэх, соёлын үнэт зүйлийг хүргэх, үндэсний хэмжээнд өргөжүүлэх ажлыг зохион байгуулах:** Олон улсын гэр бүлийн өдрийг угтаж гэр бүл дэх хүүхэд хамгаалалд эерэг нөлөө үзүүлэх, бие биенээсээ суралцах, хамтран хөгжих, харилцах, эцэг эх, асран хамгаалагчийн хөгжил оролцоогоор дамжуулан, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор 4-6 дугаар ангийн сурагчдын дунд "Угийн бичиг-Ургийн мод" гар зургийн уралдааныг зохион байгуулж 2 бүтээлийг хүлээн авч уралдаанд амжилттай оролцсон хүүхдүүдэд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр аймгийн "Жаргалан" зусланд амрах эрхийн бичгийг гардуулахаар бэлтгэсэн.

**Хоёр. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чиглэлээр:**

Хүүхдийн тусламжийн 108 утасны 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс 05-р сарын 10-ны байдлаар хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн кейсийн мэдээг гаргах, мөн графикт оруулан мэдээ бэлтгэсэн.

**Түр хамгаалах байраар үйлчлүүлэх иргэдийг хүлээн авах, хамгааллын үйлчилгээ үзүүлэх:** 04 дүгээр сарын 22-ний өдрөөс Бэлгийн хүчирхийллийн хохирогч өсвөр насны 1 хүүхэд, үл хайхрах хүчирхийллийн хохирогч бага насны-2 хүүхэд нийт 3 хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг 1-31 хоногийн хугацаанд дараах үйлчилгээг үзүүлэн ажилласан.Үүнд:

-Эрүүл мэндийн үйлчилгээ / үзлэг, шинжилгээ/

-Боловсролын үйлчилгээ/ Америкийн соёл мэдээллийн төвийн англи хэлний сургалт/

-Хөгжлийн үйлчилгээ / Хүүхдийн ордны дэргэдэх шатрын дугуйлан, хөгжмийн дугуйлан/

-Соён гэгээрүүлэх арга хэмжээ / Сургалт сурталчилгааны төвтэй хамтран музейн үзвэр үзэж таниулах, язгуур алтан өв биет бус өвийг сурталчлан таниулах арга хэмжээнд үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдээ үзүүлж таниулсан./

-Хууль эрх зүйн үйлчилгээ /Өмгөөлөл, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, сурагчийн аюулгүй байдлын дүрэм таниулах/

-Дасгал хөдөлгөөн / Бие бялдрын хөгжлийг сайжруулах зорилгоор дасгалын тогтмол хийдэг./

- 4 сарын 26-нд ШАНД СКОРПИОН ХХК-тай харуул хамгаалалтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

**Сайншанд сумын эрсдэлийн програмд бүртгэлтэй зорилтод бүлгийн хүүхдүүдэд гэрийн эргэлт зохион байгуулах:** Сайншанд сумын 2,6,8 дугаар багийн архины хамааралтай эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа 4 өрхийн 13 хүүхдийн гэрт эргэлт хийж эцэг эхчүүдэд аюулгүй байдлын зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

**Иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх:** Сайншанд сумын 8 дугаар багийн 10 эцэг эх, 6-р багийн 10 эцэг эхэд Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Хүүхдийн эрхийн тухай хуулийн талаарх сургалтыг зохион байгуулсан.

Сайншанд сумын Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг "Эко хот - 2022" зорилтот жил болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд "Эко хот –эрх зүйт иргэн арга хэмжээнд сурагчдын хууль эрх зүйн орчинг дээшлүүлэх, мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор ахлах ангийн 150 хүүхдүүдэд “Хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчин” сэдвээр сургалт, мэдээлэл тавьсан.

Зорилтот жилийн хүрээнд "Эко хот" өдөрлөгт 50 гаруй иргэдэд хүүхдийн тусламжийн 108 утас, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хялбаршуулсан таниулга, "Миний гэр аюулгүй орчин үнэлгээний хуудас", сэтгэл зүйн гарын авлага, "Өрхийн эмийн сан" зөвлөмжийг хүргэсэн.

#### **Урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон хамтарсан багийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах: Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Сайншанд сумын Хамтарсан багийн нээлттэй хэлэлцүүлгийн арга хэмжээг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явууллаа. Уг арга хэмжээнд аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, Сайншанд сум болон 8 багийн Засаг даргаар ахлуулсан Хамтарсан багийн төлөөлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын ажлын хэсэг нийт 50 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

**ХҮҮХДИЙН ЭРХ", "ХҮҮХЭД" аян:** Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 8-10 дугаар ангийн 110 гаруй сурагчдад прокурорын байгууллагатай хамтран "Хүүхдийн эрх үүрэг", "Цахим орчин", "Эцэг эхийн үүрэг хариуцлага" сэдвээр, 10-11 дүгээр ахлах ангийн 150 гаруй сурагчдад "ВЭП тамхины хор уршиг", "Хүүхдийн эрхийн тухай хуулийн ойлголт",

“Сургуулийн орчин дахь дээрэлхэлт гэж юу вэ” сэдвээр сургалт зохион байгуулж, “Хүүхдүүдээ хайрлая, Хүчирхийлэх биш хүмүүжүүлье”, “Эцэг эхчүүдэд зөвлөмж”, “Иргэн таны мэдлэгт”, “Хүүхэд бүрийн төлөө” гарын авлага, зөвлөмж нийт 1000 ширхгийг хэвлүүлж тарааж ажилласан.

-Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захиргаатай хамтран “Өсвөр үеийн дээрэлхэлт”, “Хүүхэдтэй харилцах харилцаа”, “эцэг эхийн үүрэг хариуцлага”, сэдвээр сургалт зохион байгуулсан. Нийт 50 сурагч, 2 багш хамрагдсан.

-Замын-Үүд сумын прокурорын газартай хамтран ахлах ангийн 120 гаруй сурагчдад Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын танилцуулгыг хийж үе тэнгийн гадуурхалтын талаар чөлөөт ярилцлагыг зохион байгуулсан.

Мөн тус аяны хүрээнд “Цэрэгжүүлсэн хамгаалалтын газар, Төмөр замын ажилчдад нийт 80 гаруй иргэдэд цагдаагийн байгууллагатай хамтран “Гэр бүлийн харилцаа хандлага”, “Хүүхдийн эрхийн тухай хуулиар”, “Архидан согтуурахын хор хөнөөл” сэдвээр сургалт зохион байгуулж “Хүүхдүүдээ хайрлая”, “Хүчирхийлэх биш хүмүүжүүлье”, “Эцэг эхчүүдэд зөвлөмж”, “Иргэн таны мэдлэгт” зэрэг нийт 45 гаруй гарын авлага материал тарааж ажилласан.

Нийт 430 сурагч, 82 насанд хүрэгчдэд тус аяны хүрээнд мэдээллийг хүргэж 1045 тараах материал тарааж ажилласан.

**Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах:** Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/341 дугаар захирамж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/51 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Сайншанд сумын 8 дугаар багт зохион байгуулагдсан “Хутагтын хурд-2022” бүсийн уралдаанд хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалан 7-14 насны 80 хүүхдийг уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалд даатгуулж, иж бүрэн хамгаалалтын хувцас хэрэгсэлтэйгээр уралдааны замд гарган 3 насны морьдын уралдааныг дагаж хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

**ТББ-аар дамжуулан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүрээнд:** Хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлын зохион байгуулах: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, тэдгээртэй нийцэж гарсан эрх зүйн актуудын хэрэгжилтийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, шалтгаан, хэлбэрүүдийн тухай суурь мэдлэг эзэмших, түүнээс урьдчилан сэргийлэх аргад сургах, иргэд олон нийт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг үл тэвчих, хүчирхийллийг эрт илрүүлэх, хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүрээнд хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлын зохион байгуулах төсөл”-ийн удирдамжийг “Өхөөрдөм инээмсэглэл”, “Говийн хөх салхи”, “Дорнын манлайлагч залуус” ТББ-д танилцуулах уулзалтыг зохион байгуулж, 2 ТББ-тай хамран ажиллахаар төслийг боловсруулан ажилласан.

### **3. Залуучуудын хөгжил оролцоо чиглэлээр:**

**“Өсвөрийн парламент”-ын хөтөлбөрийн хүрээнд нөлөөллийн ажил зохион байгуулж, гишүүдийг хотод сургалтад хамруулах:** Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо, Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэн, НҮБ-ын Хүүхдийн сан, People in Need зэрэг байгууллагууд хамтран, өсвөр үеийнхэнд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох үйл ажиллагааны талаар мэдлэг ойлголт өгч, шийдвэр гаргах түвшинд өсвөр үеийнхний оролцоог нэмэгдүүлэх, дуу хоолойгоо шийдвэр гаргагчдад хүргэх боломжийг олгох зорилгоор “Өсвөрийн парламент” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд улсын хэмжээнд орон нутаг тус бүрээс 2-3 сурагчийг тодорхой шалгуурын дагуу бэлтгэж, өнгөрсөн хугацаанд батлагдсан удирдамжийн дагуу орон нутаг

бүрдээ ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран 4 арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Дээрх хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод “Өсвөрийн парламент-2022” чуулган 2022 оны 05 дугаар сарын 11-14-ний өдрийн хооронд улаан зохион байгуулагдаж байгаа бөгөөд тус аймгаас ЗТХ-ийн ахлах мэргэжилтэн, ЕБС-ийн 2 сурагч оролцлоо.

ГБХЗХГ-аас өсвөр үеийнхний тулгамдсан асуудлуудын нэг болох зөв хооллолт, хоол хүнсний шим тэжээлийн талаарх “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг энэ оны 03 дугаар сараар хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн “Өсвөрийн парламент”-ын хөтөлбөрийн хүрээнд дээрх хөтөлбөрийг нэгтгэн 21 аймаг 9 дүүргийн төлөөлөл болсон 90 сурагчийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэн ажиллаж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд Сайншанд, Иххэт сумдын 2 сурагч бэлтгэгдэж байна. Тус сургагч багш нар “Өглөөний цайг өөртөө” өдөрлөгийг ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төвд зохион байгуулж өглөөний цайны ач холбогдол болон өглөөний цай уухгүй байх нь ямар хор нөлөөтэй байдаг талаар ярилцлаа. Тус нөлөөллийн ажилд 40 сурагч хамрагдлаа.

#### **Сайн дурын ажлын хүрээнд:**

1.Сайн дурын ач холбогдлын талаар сургалт болон бүртгэлийг 3 удаа зохион байгуулж 68 сайн дурын ажилтныг бүртгэлжүүлсэн.

2. Сайншанд 4 сургуулийн сурагчдын зөвлөлийн 35 төлөөлөлд 5 сарын 23-нд сайн дурын ач холбогдлын талаар мэдээлэл өгч сургууль дээрээ төсөв зарцуулахгүйгээр сайн дурын ажлуудыг хийхээр боллоо. Үүнд:

Сайншанд 1-р сургууль: Хүүхдүүдэд тулгарч буй асуудлыг талаар контент бэлдэх

Сайншанд 2-р сургууль: "Сайн үйлсийн 7 хоног" уриалга гаргаж сургуулийн багш сурагчдыг өргөн цар хүрээтэйгээр хамруулах.

Сайншанд 3-р сургууль: "Улавчтай 7 хоног" аян зарлаж үйлчлэгч нартаа туслах

Сайншанд 5-р сургууль: Бага ангийн багш нартаа туслах

Уг арга хэмжээг Говийн хөх салхи НҮТББ-ын дэргэдэх Дорноговийн сайн дурынхны төв, Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.

3. Сайн дурын ажлаар бусад сургуулиа манлайлан оролцож байгаа Сайншандын 2-р сургуулийн сайн дурын ажлуудыг орон нутгийн DTV-гээр сурталчилж уриалж ажилласан. Тус сургууль “Сайн дурын 7 хоног” аяны хүрээнд одоогийн байдлаар 20 бүлгийн 600 гаруй сурагч нэгдэж нийтийн эзэмшлийн талбай цэвэрлэх, тоглоомын талбай угаах, мод услах, хамрын хийд орчмыг цэвэрлэх зэрэг олон ажлууд хийсэн байна. Телевизийн мэдээг одоогийн байдлаар 5400 хүн үзсэн байна.

**Төрийн бус байгууллага болон залуусын бүлгийг чадавхжуулах:** Каритас олон улсын байгууллагатай хамтран Бүгд залуусын төлөө залуус бүгдийн төлөө төслийн хүрээнд 4 сарын 14-15-ны “Мониторинг хийх чадавхийг сайжруулах сургалтыг ЗХТ дээр зохион байгууллаа. Уг сургалтад төрийн бус байгууллага болон залуусын төлөөлөл 25 хамрагдаж сертификат гардан авлаа. Сургалтын бүх зардлыг ОУ-ын төслөөс гаргасан.

**Үүргэвчтэй явган аялал зохион байгуулах замаар залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх:** Говийн хөх салхи НҮТББ-ын дэргэдэх Дорноговийн сайн дурынхны төвтэй хамтран “Гайхамшигт бямба гараг” алхалтыг зохион байгууллаа. Алхалт 5 сарын 21-ны бямба гарагийн өглөөний 6 цагт гэр бүлийн талбайгаас “Салхин сэнс” хүртэл 13км алхлаа. Алхалтын хүндэт зочноор “Өсвөрийн парламент”-ийн гишүүн Б.Дэмбэрэл оролцож “Өсвөрийн парламент-2022”-т хэрхэн оролцох талаар мэдээлэл хүргэлээ. Алхалтад нийт 16 хүн оролцож, мэдлэг, танилын хүрээгээ тэлж, нөхөрлөж 1 өдрийг сонирхолтойгоор өнгөрүүллээ. Алхалт бямба гараг бүр зохион байгуулагдана.

**Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, төсөл хөтөлбөрийн мэдээллийг иргэдэд хүргэх:** Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оролцоо” төслийн талаар ЗХТ-ийн пэйжээр дамжуулан лайв хийж залуучуудад мэдээлэл хүргэн ажилласан. Зочноор ХХҮГ-ын ажил зуучлалын мэргэжилтэн С.Атарцэцэг оролцлоо. Уг лайв 473 хүнд хүрсэн байна.

Залуучууды хөдөлмөр эрхлэлтийн “Старт ап” арга хэмжээний мэдээллийг ЗХТ-ийн пэйжээр дамжуулан 3 удаа хүргэж 2 иргэнийг ХХҮГ-тай холбож өгсөн.

**"Залуусаа сонсох өдөр" арга хэмжээний хүрээнд:** "Залуусаа сонсох өдөр" арга хэмжээний хүрээнд Сайншанд сумын 4 сургуулийн өсвөр насны сурагчдыг оролцуулан "ХҮҮХДҮҮД ЯРЬЖ БАЙНА" хэлэлцүүлэг зохион байгуулж сурагчдад тулгамдаж байгаа асуудлыг ярилцаж, уг асуудлыг хүүхдүүд болон хүүхдийн оролцооны байгууллага хөрөнгө шаардахгүйгээр өөрсдийн хүрээнд шийдвэрлэхээр боллоо.

Сургуулиуд дээр хамгийн их тулгарч буй асуудлыг эрэмбэлвэл:

1. Цайны газрын хүртээмж муу, хоолны орц хангалтгүй
2. Их завсарлагааны хугацаа богино
3. Нойлын асуудал хүндрэлтэй, /хаалга нь цоожгүй, намхан хаалгатай, эр эм нойл хамтдаа...
4. Охидын хувцас солих өрөө байддаггүй /Биеийн тамирын хичээлд/
5. Багшийн ёс зүйгүй байдал гэх зэрэг 12 асуудал болон шийдлийг ярилцлаа.

Хүүхдүүд өөрсдийн сургууль дээрх асуудлуудаас 1 асуудлыг сонгон авч шийдвэрлэхээр боллоо. Үүнд:

Сайншанд 1-р сургууль: Сургуулийн нойлын одоогийн байдлыг сайжруулах

Сайншанд 2-р сургууль: Номын санг хүртээмжтэй болгох, ном цуглуулах замаар номын фондыг нэмэх

Сайншанд 5-р сургууль: ХОБ-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг асуудлыг өөрсдийн хүчээр шийдвэрлэхээр боллоо. Уг арга хэмжээнд 35 хүүхэд хамрагдлаа.

**Амьдрах ухаан, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:** Байгууллагын албан хаагчдад “Гэр бүлийн үнэ цэнэ, Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг “Цаг, уур, орчны шинжилгээний газар, Хот тохижилтын газар, Стандарт хэмжил зүйн газар”-т тус тус зохион байгуулав. Сургалтад нийт 73 албан хаагч хамрагдаж, гэр бүлийн харилцаанд тулгамддаг асуудлаа хэрхэн шийдвэрлэх, эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа, түүнийг ойлгон хүндэтгэх, амьдралын идэвх оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн насны онцлог болон түүнд тохируулан харьцах талаар мэдлэг, мэдээллийг өгч ажилласан.

Гэр бүл, эцэг эхчүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаарх мэдлэг олгох зорилгоор Сайншанд сумын 8, 6 дугаар багийн 20 иргэнд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг зохион байгуулан ажилласан. Сургалтын үр дүнд эцэг, эхчүүд хүүхдийнхээ насны онцлогыг танин мэдэх, онцлогт нь тохируулан харьцах, 0-6 насны хүүхдийн хөгжлийн явц зэрэг зөвлөгөө мэдээллийг хүргэлээ.

#### **4. 2022 оны бодлого төлөвлөлт:**

##### **Олон улсын Гэр бүлийн өдрийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах:**

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан тус байгууллагаас 05 дугаар сарыг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих сар” болгон зарласан. Гэр бүлийн хөгжлийг дэмжих сарын хүрээнд байгууллагын даргын 2022 оны 140 дугаар албан бичгээр аж ахуйн нэгж албан байгууллага, сумдад чиглэлийг хүргүүлсэн. Сумдад гэр бүлд чиглэсэн сургалт хэлэлцүүлэг, 5 төрөлд спортын арга хэмжээ, гэр бүлийн зөвлөгөөн, гэр бүлтэйгээ цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор хөгжөөнт тэмцээн, уран уншлага, гэр бүлийн тайлан тоглолт зэрэг 7 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 2428 иргэн, хүүхэд багачуудыг оролцуулсан. Дээрх арга хэмжээнд нийт 4085,0 мянган төгрөгийг зарцуулсан. Мөн аж ахуйн нэгж байгууллагууд эцэг эхийн зөвлөлөөрөө дамжуулан “Гэр бүлийн хөгжлийг дэмжих сар”-ын хүрээнд албан хаагчдад гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран цагийг өнгөрүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 5 байгууллага хүүхдийн өрөөг шинээр тохижуулсан. Энэхүү арга хэмжээнд байгууллага болон эцэг эхийн зөвлөл, албан хаагчдаас нийт 5137,7 мянган төгрөгийг зарцуулсан. Мөн “Эрүүл гэр бүл”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” зэрэг сэдвийн хүрээнд гэр бүлийн сургалт хэлэлцүүлгийг 8 байгууллагын 113 албан хаагчид, тэдний гэр бүлд тус байгууллагаас

зохион байгуулсан. Түүнчлэн “Миний гэр аюулгүй орчин” хүүхдийн эрсдэлийн үнэлгээ, гэр бүл, хүүхэд багачуудынхаа дунд төрөл бүрийн хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан, музей үзүүлэх, цэвэр агаарт гэр бүлийн өдрийг тэмдэглэх, албан хаагчдынхаа гэр бүлд талархлын захиа хүргүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулж нийт 963 албан хаагч, тэдний гэр бүлийг оролцуулсан.

Тус байгууллагаас зарласан “Гэр бүлийн хөгжлийг дэмжих сар”-ийн хүрээнд сумд болон байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан 15 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 3391 иргэнийг оролцуулж, арга хэмжээнд 11266,8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Гэр бүл, хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлдээ цагийг зарцуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх, гэр бүлийн сайн сайхны төлөө аж ахуйн нэгж байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан арга хэмжээг зохион байгуулсан үр дүнтэй.

**“Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн орон нутгийн чуулган”-ыг зохион байгуулах:**

“Хүүхэд хөгжил-2022” зорилтот жил болгон зарласантай холбогдуулан “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн орон нутгийн чуулган”-ыг аймаг, орон нутгийн хэмжээнд салбар байгууллага, ажилтан бүр хүүхдийн өмнө үүрэг хүлээгч гэдгээ ухамсарлан, тэдний эрх ашгийг хүндэтгэн, аливаа хүчирхийлэл, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд гар бие оролцон, хүүхэд хамгааллын асуудлыг нэн тэргүүнд тавих, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, гарц шийдлийг олох зорилгоор зохион байгуулсан. Тус чуулганд Аймгийн засаг дарга, хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн О.Батжаргал, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ч.Байгалтуяа, Хууль зүйн хэлтсийн дарга Ч.Нандин-Эрдэнэ, ГБХЗХГ-ын дарга Л.Цэцэгдарь болон хууль, шүүхийн байгууллага, Боловсрол, эрүүл мэнд, Төмөр зам, МХГ, аймгийн ИТХ-ын дэргэдэх салбар хороодын төлөөлөл, хэвлэл мэдээлэл, байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл, сурагчдын төлөөлөл нийт 30 гаруй хүн оролцсон.

Чуулганаар:

- 1.Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргийн нөхцөл байдал, шийдвэрлэх арга зам
2. Хүүхдийн эрхийг хангахад орон нутгийн зүгээс баримталж буй бодлого, стратеги, төсөв, хүний нөөц, чанартай статистик, мэдээллийн сангийн үзүүлэлт
- 3.Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

**“Хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгуулах:** “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жил болгон зарласантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/249 дугаар захирамжаар “Хүүхдээ сонсох өдөр”-ийг сар бүрийн эхний долоо хоногийн 3 дахь өдөр зохион байгуулахаар товлосон. Тус өдрийн хүрээнд 05-р сарын 04-ны өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сургалтын танхимд нийт 47 сурагч, зочноор ГБХЗХГ-ийн дарга Л. Цэцэгдарь, аймгийн ИТХ-ын хурлын ажлын албаны дотоод ажил хариуцсан мэргэжилтэн С.Мөнхнаран, аймгийн нийгмийн бодлогын боловсрол хариуцсан мэргэжилтэн н.Эрдэнэжаргал нар уригдан сурагчдын дуу хоолой, санал хүсэлт тулгамдаж байгаа ажлыг сонсож санаа бодлын сонслоо. Хүүхдүүдийн өмнө тулгамдсан аливаа асуудлаар харилцан ярилцан, олон талаар тэдний санал бодлыг сонсож цаашлаад удирдах дээд шатны албан тушаалтанд хүргэж ажиллахаар боллоо.

**Хүүхдийн зуслангийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах:** “Жаргалан” хүүхдийн зуслангийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

**Залуучуудын салбар зөвлөлийг хуралдуулж 2021 оны тайланг тавьж 2022 оны төлөвлөгөөг батлуулах:** Дорноговь аймгийн Залуучуудын Салбар Зөвлөлийн хурлыг 05 дугаар сарын 11-ны өдөр хуралдуулан 2022 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж гишүүдээс гарсан саналыг төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Уг

төлөвлөгөөнд залуусын оролцоо, эрүүл мэнд, боловсрол-соёл урлаг, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй орчин 5 чиглэлээр 28 санал хэлэлцүүлэгдэн батлагдсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн албан даалгаврын дагуу Хүүхэд хамгааллын ажилтнууд болон хамтарсан багийн гишүүдийн аюулгүй байдал, ажиллах нөхцөлийг хангах үлгэрчилсэн зааврыг боловсруулсан. Мэргэжлийн ангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж “Үлгэрчилсэн заавар”-ыг хавсралтад оруулахаар бэлтгэсэн.

#### **2.4. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

##### **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

- Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин тавигдах байгалийн хийн хоолойн төслийн хүрээнд Дорноговь аймгийн Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дээр байрлах “Союз Восток” хий дамжуулах хоолойн барилгын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/245 дүгээр захирамжаар байгуулсан ба холбогдох сумдад инженерийн иж бүрэн судалгаа хийх зөвшөөрлийг олгосон. Холбогдох баримт бичгүүдийг “Эрдэнэс газ” төслийн нэгжид хүргүүлсэн.

- Монгол Улсын төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан томоохон хэмжээний ордуудыг холбох дэд бүтцийн сүлжээ байгуулах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сайншанд өртөө”-ний замын хөгжлийг зангилаа өртөө хэлбэрээр өргөтгөж хөгжүүлэх, “Зүүнбаян” өртөөг өргөтгөх төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар “УБТЗ” ХНН-ийн ажлын хэсгээс танилцуулга хийж, уг асуудлыг шийдвэрлэхэд ажлын хэсгүүд хамтарч ажиллахаар болов.

- Сайншанд сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэн Ганхүрэлийн захиалгаар “Айсуй хөгжил” ХХК-ийн гүйцэтгэсэн Авто засварын газрын барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргасан.

- Газар өмчлөх эрх шилжүүлэхээр хүсэлт гаргасан 10 иргэний хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

- Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн итгэлцүүр хэрэглэх газрын хил зааг, итгэлцүүрийн утгыг тогтоох тухай аймгийн ИТХ-ын тогтоолыг, Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн.

- Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Барилгачдын холбоо хамтран "Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-Цахим шилжилт 2022" зөвлөгөөнийг зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд Дорноговь аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч, холбогдох албан тушаалтнууд, тус аймагт бүтээн байгуулалт хийж буй барилгын салбарын захирал, инженер техникийн ажилчдаас бүрдсэн 80 гаруй төлөөлөгч оролцов.Төрийн байгууллагын бүх үйлчилгээ цахимжиж байгаатай холбогдуулан барилгын салбарт хийгдэж байгаа цахим үйлчилгээ, цахим статистик мэдээ тайлангийн талаар оролцогсдод мэдээлэл зөвлөгөө өгч байгаагаараа онцлог боллоо. Мөн аймгийн ЗДТГ, ГХБХБГ, МХГ, ОНӨГ-аас холбогдох мэдээллүүдийг хүргэсэн байна. Зөвлөгөөний төгсгөлд цар тахлын нөлөөгөөр материалын үнийн өсөлт, хил гааль, тээврийн асуудал барилгын салбарт тулгамдаж буй асуудлууд хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг

өрнүүлж орон нутгийн удирдлагуудтай харилцан санал бодлоо солилцсоны дараа орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудтай газар дээр нь танилцлаа. Зөвлөгөөнд оролцсон орон нутагт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд "Хүүхдэд ээлтэй орон нутаг", "Хүүхэд хөгжил-2022" зорилтот жилийг дэмжиж, Сайншанд суманд шинээр баригдсан Хүүхдийн зусланд өөрсдийн хөрөнгө оруулалтаар усан оргилуур барихаар шийдвэрлэлээ.

- Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх 5 хүсэлтийг шийдвэрлэж зөвшөөрөл олгосон.

-Газар эзэмшүүлэх ашиглуулах дуудлага худалдааг 7 сумын 24 нэгж талбарт газрын цахим биржээр зарласан, 6 дугаар сард зохион байгуулагдана.

### **Дэд бүтцийн чиглэлээр:**

- Сумын Засаг даргын захирамжаар эзэмшил газраа 2 жилээс дээш хугацаанд зориулалтын дагуу ашиглаагүй иргэний газрыг хураан 2 дугаар сургуулийн арын замыг офицерын төв замтай холбох 0,577км авто замын трасс-д давхцсан айлд олгон нүүлгэн шилжүүлэх ажлыг шийдвэрлэсэн.

- Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам болон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой уурхайгаас Хатанбулаг сумын Ханги хилийн боомт хүртэл тавигдах авто замтай огтлолцож буй хэсэгт төмөр замын гармыг хэрхэн шийдвэрлэх талаар 05 дугаар сарын 31-ны өдөр Аймгийн удирдлага болон гүйцэтгэгч компанийн төлөөлөлүүдтэй өргөтгөсөн хуралдаан хийсэн. 2 гүйцэтгэгч компани 06 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотод уулзаж гармыг асуудлыг шийдвэрлэн буцаж 06 дугаар сарын 06-ны өдөр Аймгийн удирдлагуудад танилцуулахаар болсон.

- 11-11 төвд хандан төрийн үйлчилгээний талаар гомдол гаргасан 4 иргэний 5 өргөдлийг судалж, 2 өргөдлийн хариу өгсөн байна.

- Мандах наран-5 болон Саран хөхөө театрын дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээний өндөржилт зөрж авто замтай давхцсал үүссэн. Уг асуудлыг шугам сүлжээ болон замын автортай уулзаж өөрчилж зурахаар тохирсон.

- Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/332 дугаар захирамжаар Сайншанд өртөөний үйл ажиллагааг өргөтгөх хамтарсан ажлын хэсэг байгуулсан.

- Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн маршрут хүссэн Айраг суманд үйл ажиллагаа явуулж эхэлж буй "Алтраг-Ахас" ХХК-ийн хүсэлтийг судалж байна.

### **Байгаль орчин, уул уурхайн чиглэлээр:**

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хаварын мод тарих арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 667 өрх, 4318 ширхэг мод, 216 аж ахуйн нэгж байгууллага орчиндоо 22230 ширхэг мод тарьж, шинээр 8 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулагдаж 90,0 орчим мянга модыг тарьж, 216 аж ахуйн нэгж байгууллага, 3300 гаруй иргэд оролцлоо.

Батлан хамгаалах яамтай хамтран хэрэгжүүлж буй Мод үржүүлэг-Агро экологийн төвийн нээлт, Хүүхдийн зуслан 2 төрлийн 12000 орчим мод тарих ажлыг 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж 18 байгууллагын 260 гаруй албан хаагч оролцон гүйцэтгэсэн. Мөн "Эко хот-2022" зорилтот жилийн нээлтийн арга



хэмжээнд модны тарьц суулгац, ургамлын үр үрсэлгээ, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, хог хаягдал ялган ангилах сургалт мэдээллийг өгч ажилласан.

“Хот суурин газрын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах агаар, орчны бохирдлыг бууруулах, ногоон байгуулжийн талбайг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд 2030 он хүртэл Олон Улсын жишигт нийцсэн “THE PARK OF GOBI” буюу “Говийн парк” цэцэрлэгт хүрээлэнг Сайншанд сумын 8-р багийн нутаг дэвсгэр буюу Наамдын талбайн орчимд нийт 110 га талбайд байгуулахаар төлөвлөж нээлтийн арга хэмжээг “Ухаалаг хот-Ногоон Дорноговь” уриан дор 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Нээлтийн үеэр цэцэрлэгт хүрээлэнгийн эхлэлийг тавьж 2 га талбайд, төрлийн, 4270 мод тарих ажлыг 102 иргэн, 90 аж ахуйн нэгж, байгууллагын 1400 орчим хүн оролцсон байна.

Дэлгэрэх суманд 3 га талбайд “Дэлгэрэх-100” цэцэрлэгт хүрээлэн, Мандах суманд 0,12 га талбайд “Дэнж”-ийн цэцэрлэгт хүрээлэн, Хатанбулаг суманд “Загийн овоо” гэх газарт 8 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлууд хийгдэж байна.

“Өнгө нэм”ТББ-тай хамтран Сайншанд сумын Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж хог ялган ангилах зориулалтын савыг 7 байршилд шинээр тавьж, нөлөөллийн ажлыг эхлүүлээд байна. Уг ажилд аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас нийт 29,9 сая төгрөгийг санхүүжүүлэн дэмжлэг үзүүлсэн.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг бүх салбарт хэрэгжүүлэхээр зорьж Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн сурагчдад экологийн мэдлэг олгох танин мэдэхүйн аялал, “Цахим музей”, 1000 цэцгийн баяр зэрэг хүүхдэд чиглэсэн нөлөөллийн ажлыг тус тус зохион байгуулж нийт уг арга хэмжээнд нийт 1000 гаруй хүүхэд хамрагдсан.

Сайншанд сум "ЭКО ХОТ-2022" зорилтод жилийн хүрээнд Сайншанд хотын зүүн бүсийн 4, 6, 11, 12, 13 цэцэрлэгүүд тайлангаа тавин 1000 цэцгийн үзэсгэлэнг гаргаж иргэдэд танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.

### **Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

- 2022 онд нийт УТ-ийн 157.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 инженерийн хийцтэй худаг гаргах, СОНХС-ын 420.0 сая төгрөгийн хөрөнгөөр 21 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргахаар төлөвлөгдсөн ба УТ-ийн хөрөнгө оруулалтаар 5 инженерийн хийцтэй худаг гаргах тендерийг зарлаж “Эхний эхэн” ХХК шалгарч ажлаа эхлүүлсэн.

- “Нийтийн хоолны газрын тогооч, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн түвшин тогтоох үнэлгээ хийх” сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 18 өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд зохион байгуулж 8 сумын 30 тогооч хамрагдав.

-“Говийн амт-Говийн брэнд” хоолны үзэсгэлэнг 2022 оны 05 дугаар сарын 21-нд зохион байгуулж 9 сумын 30 тогооч 14 баг болж 21 төрлийн хоол, 7 төрлийн зуушаар оролцож иргэдэд эрүүл зөв хооллолтын талаар мэдээлэл өгч ажилласан.

-2022.05.30-ны байдлаар хүнсний хангамж тооцоход малын мах 78.55 тн, гурил 136.4 тн, гурилан бүтээгдэхүүн 14.9 тн, төрөл бүрийн будаа 34.22 тн, хуурай сүү 10.45

тн, өндөг 1.59 тн, ургамлын тос 21.5 тн, төмс 71.1 тн, хүнсний ногоо 32.4 тн, элсэн чихэр 17.3 тн, давс 15.3 тн, савласан усны 61.5 тн нөөцтэй байна.

-Хүн амын 2022 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн хөрөнгөөр махны нөөц бэлтгэх тэндэр зарлан “Суман зурхай” ХХК оролцон шалгарч дотоодын хэрэгцээнд үхэр, хонь, нийт 25 тн махны нөөцийн бүрдүүлэн 2022 оны 05 дугаар сарын 09-өөс эхлэн Сайншанд сумын 4 цэгт зах зээлийн үнээс 1 кг тутмыг 2000 төгрөгийн хямд үнээр худалдан борлуулж өнөөдрийн байдлаар үхрийн 13.5 тн, хонины 2.8 тн мах нийт 16.3 тн махыг худалдаанд нийлүүлсэн байна.

- Согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр 1 аж ахуйн нэгжид олгож, 14 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан.

- Монгол морьтны үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлж сурталчлах зорилгоор “Хутагтын хурд-2022” хурдан морины уралдаан 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж Соёолон, Хязаалан, Их нас гэсэн 3 насны морьд уралдуулж, 2 төрлийн монгол морьтны өв соёлын тэмцээнийг зохион байгууллаа.

-Монгол Улсын Засгийн газраас 2022 оныг “Хоршооны хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх, сурталчлах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг болон хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/361 дүгээр захирамжаар батласан.

Төлөвлөгөөний дагуу жижиг, дунд үйлдвэрийн газар Канадын MERIT төсөлтэй хамтран зохион байгуулж буй “Хамтран суралцаж, харилцан туршлага солилцох индэр, ЖДҮ, төсөл хөтөлбөр, санхүүгийн боловсролын чиглэлээр 3 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 9 сумын 21 албан хаагчийг хамруулан мэдлэг, мэдээллээр ханган ажилласан.

## **2.5 САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛЭЭР**

### ***Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:***

- Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтэд 95.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Орон нутгийн төсвийн байгууллагад 1.8 тэрбум төгрөг, сумдын санхүүгийн дэмжлэгт 180,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтоор 804.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Орлогын төлөвлөгөө 5 сарын байдлаар 15.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 21.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 6.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэнүүд 2022 оны 05 сарын 01-5 сарын 31-ны хооронд нийт 1000 гүйлгээний 17.5 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог төлбөрийн хүсэлт, хяналтын хуудас анхан шатны баримтын бүрдлийг хянаж Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан ажилласан.
- Нэмэлт санхүүжилтийн 45 байгууллагын хүсэлтийг үндэслэн 1.4 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.

- Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн тодотгол боловсруулах ажил хийгдэж байна.
- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд аймгийн харьяа 151 төсвийн байгууллага 100% цалингаа илгээж байна.
- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд байгууллагын дарга чөлөөлөгдөн, шинээр томилогдсон 2 даргын хүсэлтийг үндэслэн баталгаажуулан ажилласан.
- Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 9 сумын 31 ажлын 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн баримтын бүрдлийг хянаж Засаг даргын зөвшөөрлөөр олгосон.
- Даланжаргалан сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнээр Г.Эрдэнэсүвдыг зөвшилцсөн албан бичгийг гаргасан.
- Татварын урьд оны өрийн барагдуулалтад аймгийн төсөвт 42.5 сая төгрөг, сумын төсөвт 6.4 сая төгрөгийн өрийг барагдуулсан.
- Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн хүсэлтийг үндэслээд 1.4 5тэрбум төгрөгийн хүсэлтийг засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд залруулгыг хийж ажилласан.
- Газрын дуудлага худалдаанд ялагч болоогүй 4 иргэн аж ахуй нэгжийн 390.0 мянган төгрөгийг буцаан олгосон.

### **Санхүүгийн хяналт, аудитын алба**

**Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:** Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

#### **Цаг үеийн ажлын мэдээлэл:**

- Аймгийн Засаг даргаар батлуулсан 2022 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 02 тоот удирдамжуудийн дагуу аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТГазрын 2020, 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийгдэж буй хяналт шалгалтыг үргэлжлүүлэн хийж байна.
- Аймгийн Засаг даргаар батлуулсан 2022 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 04, 05, 06, 07 тоот удирдамжаар Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1, 3 дүгээр сургууль болон Насан туршийн боловсролын төв, Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг эхлүүлсэн.
- Замын-үүд сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тэмдэглэлийг дуусгаж, 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 90 тоот албан бичгээр хүргүүллээ.
- Аймгийн Засаг даргаар батлуулсан 2022 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 01 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Зүүнбаян багийн төсөвт байгууллагуудын 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын нэгдсэн актыг бичиж, Зүүнбаян багийн Засаг даргад 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 93 тоот албан бичгээр, шалгалтын дүнгээр цаашид авах арга хэмжээний санал бүхий зөвлөмжийг төсвийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад албан бичгээр хүргүүлсэн.
- Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Ерөнхий аудиторовын 2021 оны А27 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 112 тоот албан бичгээр Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлэн ажилласан.

- Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих сургалтанд бүх албан хаагчид хамрагдсан.
- Хяналт шалгалтаар тогтоогдсон актны төлбөрөөс тайлант хугацаанд нийт 4,30987.9 мянган төгрөгийг барагдуулсан.

#### **Статистикийн хэлтэс:**

##### ***Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:***

- Долоо хоног бүрийн даваа гаригт судалдаг гол нэр төрлийн 32 бараа, бүтээгдэхүүний үнийг Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI програмд шивэн, хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд дамжуулав. Мөн 14 сумаас гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг судалж танилцуулга бэлтгэн 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар тогтмол тархааж байна.
- Сар бүрийн аж үйлдвэр /АҮ-1, зоогийн газрын үйл ажиллагааны сарын тайлан /А-ЗГ-1/, зочид буудлын газрын үйл ажиллагааны сарын тайлан /А-ЗБ-1/, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа, худалдааны салбарын 4-р сарын мэдээ, хөдөө аж ахуйн /ХАА-1,ХАА-2,ХАА-3/ мэдээ тайланг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж программд шивж ҮСХ-д хугацаанд нь дамжуулсан.
- Статистикийн хэлтсийн даргын баталсан “Сумдын статистикийн үйл ажиллагаанд хийх Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил”-ын удирдамжийн дагуу 2022 оны 05 сарын 23-ны өдөр Алтанширээ суманд ажиллалаа. Сумын статистикийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт үнэлгээ хийж, ажил сайжруулах илтгэх хуудсыг, албан тоотын хамт сумын Засаг даргад хүргүүлэв. Энэ үеэр аймгийн хөгжлийн индексийн суурь үзүүлэлтүүд, орон нутгийн давуу болон сул тал болон цаашид аль салбарын ямар үйлдвэрлэл, үйлчилгээнд анхаарч ажиллах талаар санал, зөвлөмжийг өгч ажиллалаа. Монгол Улсын "Статистикийн тухай" болон "Зөрчлийн тухай" хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, статистикийн мэдээ, тайлангийн үзүүлэлтийг зөв ойлгох, маягтыг зааврын дагуу бүрэн нөхөх, алдаа гарсан тохиолдолд алдааны залруулгыг хийх чиглэлээр анхан шатны нэгжид ажиллаж байгаа Алтанширээ сумын Төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нар болон холбогдох бусад мэргэжилтнүүдэд нэгдсэн ойлголт өгч ажиллалаа.
- Өрхийн нийгэм эдийн засгийн 5-р сарын судалгаанд Сайншанд, Алтанширээ, Өргөн, Замын үүд сумдад судлаач Мөнхболор, Мөнх Эрдэнэ, Анхчимэг нар, Ажиллах хүчний 5-р сарын судалгаанд Эрдэнэ, Айраг сумдаас судлаач Мөнх-Эрдэнэ, Мөнхболор нар Үндэсний Статистикийн хорооноос ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу түүвэрт сонгогдсон өрх бүрд хүрч судалгааг зохион байгуулж явууллаа.
- ҮСХ-оос 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Хөдөө аж ахуйн тооллого”-ын цахим сургалт, зөвөлгөөнд оролцож тооллогын бэлтгэл ажлын явц, цаашид анхаарах асуудлаар мэдээлэл солилцож, нэгдсэн нэг чиглэл, үүрэг даалгавар авлаа.

#### **Орон нутгийн өмчийн газар**

##### ***Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:***

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тендер зарласан 2, үр дүн гарч гэрээ байгуулсан 6, зарлагдаагүй 2, Сангийн яам хүчингүй болгосон 1 ажил байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Тендер зарласан 8, Тендерийг нээн үнэлгээ хийгдэж байгаа 3, үр дүн гарч гэрээ байгуулах эрх олгогдсон 22, тоо хэмжээ ирээгүй тул зарлагдаагүй 2, Сангийн яам хүчингүй болгосон 2 ажил байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тоо хэмжээ ирээгүй тул зарлагдаагүй 1 ажил байна.
- Замын сангийн хөрөнгө оруулалтаар Тендер зарласан 1, үр дүн гарч гэрээ байгуулах эрх олгогдсон 3, зарлагдаагүй 2, нийт 54 ажил байна.

➤

#### **ӨМЧ**

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хангах хүрээнд мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн. Уг тооллогын явцын талаар мөн арга зүйн зөвлөгөө өгөх талаар Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу ажлын хэсэг хойд таван сум буюу Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ сумдаар ажиллаж байна. 3 сургуулийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг хянан баталгаажуулж хүргүүлээд байна. Дорноговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 58 дугаар тогтоолоор Иххэт сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй УАЗ-469 маркийн авто машин, Айраг сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Nissan note маркийн авто машиныг худалдан борлуулахаар шийдвэрлэгдсэний дагуу дуудлага худалдааг зохион байгуулсан.

### **2.6 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 0550 дугаар сарын 195 дугаар “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцлыг батлах, эрх олгох тухай “1 тогтоол, 2022 оны 04 дүгээр сарын “Газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай, “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайлангийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай болон 05 сарын “Яам болон аймаг, нийслэлийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай”, “Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай”, “Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай”, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулсан тухай” гэсэн нийт 6 хуралдааны тэмдэглэлийг тус тус хяналтад авч, удирдлагуудад танилцуулж ажилласан.

Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй танилцаж, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу боловсруулах арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Агентлаг сумдын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд нэгдсэн сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

